

# ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА НЬ

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ  
УЛААНБААТАР ХОТ:  
ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

**ЭМНЕСТИ**  
**ИНТЕРНЭШНЛ**



Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас  
2016 онд анх удаа хэвлэв  
International Secretariat  
Peter Benenson House  
1 Easton Street  
London WC1X 0DW  
United Kingdom  
www.amnesty.org

© Эмнести Интернэшнлийн хэвлэл, 2016 он

Индекс: АСА 30/4933/2016

Эх хэл: Англи

Эмнести Интернэшнлийн Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, Их Британи,  
Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

[ISBN:]

[ISSN:]

Энэ хэвлэл нь зохиогчийн эрхтэй хэдий ч нөлөөлөл, кампанит ажил, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор төлбөргүйгээр аль ч хэлбэрээр олшруулж болох ч, худалдаалахгүй. Ингэхдээ үр нөлөөг үнэлүүлэх зорилгоор зохиогчид бүртгүүлэхийг хүсэж байна. Бусад зорилгоор энэ номыг хэвлэх, өөр хэвлэлд ашиглах, орчуулах, эсвэл өөрийн онцлогт тохируулан хэрэглэх бол зохиогчийн зөвшөөрлийг урьдчилан бичгээр авах ёстой бөгөөд тодорхой хэмжээний төлбөр төлж болзошгүй. Зөвшөөрөл авах, тодруулах зүйл байвал [copyright@amnesty.org](mailto:copyright@amnesty.org) хаягаар холбогдоно уу.

Нүүрний зураг: Эмнести Интернэшнл

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн ноцтой зөрчлийг таслан зогсоох зорилгоор дэлхийн 150 гаруй улс, бүс нутагт тэмцэж буй 7 сая гаруй дэмжигчийг нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм.

Бид хүн бүрд Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхийг хүсдэг.

Бид аль нэгэн засгийн газар, улс төрийн үзэл баримтлал, эдийн засаг, шашны сонирхлоос ангид байж, гишүүдийнхээ татвар, олон нийтийн хандиваар санхүүждэг.

**ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНЛ**



# ГАРЧИГ

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ	7
Судалгааны дүн, зөвлөмж	8
Арга зүй	12
1. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХ: ДОТООДЫН БОЛОН ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ	14
1.1 Монгол Улсын Үндсэн хууль	14
1.2 Хүний эрхийн талаарх олон улсын эрх зүй, хэм хэмжээ	15
2. УЛААНБААТАР ХОТЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ	20
2.1 Улаанбаатар хотын хүн амын өсөлт, орчны бохирдол	20
2.2 Дахин төлөвлөлтийн хөтөлбөр	22
2.3 Дахин төлөвлөлтийн санхүүжилт	24
3. ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ	26
3.1 Газар өмчилж, эзэмшээгүй хүмүүсийн хувьд ямар нэгэн эрх эдлэх боломжгүй байдал	27
3.2 Орон гэргүй болох эрсдэл	28
3.3 Сайн дурын үндсэн дээр үү эсвэл заавал нүүх ёстой юу	31
3.4 Дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам болон оршин суугчдын эрхийн талаарх тодорхойгүй зүйлс	33
3.5 Зөрчигдсэн эрхээ хамгаалуулах эрх	35
4. ДҮГНЭЛТ, ҮНДСЭН ЗӨВЛӨМЖ	38
4.1 Гол үр дүн	38
4.2 Зөвлөмж	39
ХАВСРАЛТ: ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ТӨЛӨВЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО	41

4 ХАНГАЛГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА НЬ  
МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТ: ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

1.	ДОТООДЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ	41
	Хот байгуулалтын тухай хууль ба хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль	41
	Дахин хөгжүүлэх төслийн хяналт	45
2.	ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ	46
	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам	47
	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам	50
3.	ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД	53

## ТОВЧИЛСОН ҮГС

<b>АХБ</b>	Азийн хөгжлийн банк
<b>Аймаг</b>	Мужтай адилтгахуйц Монгол Улсын засаг захиргааны нэгж
<b>Хот байгуулалтын тухай хууль</b>	Хот байгуулалтын тухай хууль
<b>ГХДБГ</b>	Гэр хорооллын дэд бүтцийн газар (өмнө нь Гэр хорооллын хөгжлийн газар байсан)
<b>ГХОСТ</b>	Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл
<b>Гэр</b>	Монгол Улсад нүүдэлчин малчдын ашигладаг дугуй хэлбэртэй эсгий сууц
<b>Гэр хороолол</b>	Нийгмийн болон инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдоогүй гэр, байшинтай хороолол
<b>НЕТГ</b>	Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар
<b>Гэр хорооллын дахин төлөвлөлтийн журам</b>	Гэрийн хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам
<b>ЭЗНСЭОУП</b>	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт
<b>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны журам</b>	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, дахин барих үйл ажиллагааны журам
<b>Шаардлага хангахгүй нийтийн орон сууц</b>	Ашиглалтын шаардлага хангахгүй гэж тогтоогдсон орон сууцны барилга
<b>ЖАЙКА</b>	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
<b>Хашаа</b>	Газар дээр тойруулж барьсан зүйл
<b>Хороо</b>	Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж бөгөөд хороодоос дүүрэг бүрдэнэ.
<b>Ерөнхий төлөвлөгөө</b>	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага - орон сууц, худалдаа, ногоон бүсийг хөгжүүлэх төлөвлөгөө бүхий Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий стратегийн баримт бичиг
<b>ХЭҮК</b>	Хүний эрхийн үндэсний комисс
<b>Газар өмчлөгч</b>	Тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээд
<b>Газар эзэмшигч</b>	Тухайн газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээд

<b>Төсөл хэрэгжүүлэгч/хувийн барилгын компани</b>	Дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэхээр сонгогдсон хувийн барилгын компани
<b>Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль</b>	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль
<b>Сум</b>	Улаанбаатар хотоос гадуурх, аймгийг бүрдүүлдэг засаг захиргааны нэгж
<b>Хөлслөгч/түрээслэгч</b>	Газар эсвэл орон байрыг түрээслэж байгаа хүн
<b>НҮБ-Хабитат</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр

## МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ЗУРАГ



# ТАЙЛАНГИЙН ХУРААНГҮЙ

«Манай хашаанд 14 хүн амьдардаг байлаа. Хэрэв бид газраа чөлөөлбөл компани нэг өрөө хоёр байр өгнө гэсэн. Манай хүү эхнэр, гурван хүүхдийнхээ хамтаар гэрийг маань бариад хаа сайгүй л буусан. Тэд 3 удаа нүүсний эцэст одоо Улаанбаатар хотоос 10 км хол газар амьдарч байна. ... Манай хүүгийн даямар нэгэн нөхөн олговор олгоогүй»

Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны иргэнтэй 2016 оны 3 дугаар сарын 20-ны өдөр хийсэн ярилцлагаас.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод оршин суугчдыг орон байраар хангах, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, орчны бохирдолтой тэмцэхээр дахин төлөвлөлтийн томоохон хөтөлбөр хэрэгжиж байна. Энэхүү хөтөлбөр, үйл ажиллагаа Улаанбаатар хотын 1,3 сая хүн амын 60 хувь амьдардаг гэр хороолол, ашиглалтын хугацаа хэтэрч, чанаргүй нь тогтоогдсон нийтийн зориулалттай орон сууцанд амьдарч буй иргэдэд чиглэсэн юм.

Гэр хороололд үндэсний уламжлалт орон сууц болох эсгий гэр ба хувийн жижиг байшингийн аль аль нь байдаг бөгөөд ихэнхдээ дулаан, цэвэр болон бохир усны дэд бүтцэд холбогдоогүй байдаг. Гэр хорооллын иргэдийн ихэнх нь өвлийн зуднаар малгүй болсон малчид эсвэл өөрийн болон гэрийнхнийхээ амьжиргааг дээшлүүлэх гэж хотод ирсэн хүмүүс байдаг. Сүүлийн 10 гаруй жилд хэдэн зуун мянган малчин өрх хөдөө орон нутгаас нийслэлийг зорин ирж Улаанбаатар хотын захад эзэнгүй газар олоод хашаа хатган, гэр барьж амьдардаг ажээ.<sup>1</sup>

Дахин төлөвлөлт хүмүүсийг их бага хэмжээгээр нүүлгэхэд хүргэдэг. Олон нийтийн оролцоо, эрх зүйн зайлшгүй, шударга процесс (due process), хангалттай нөхөх олговор олгох хүний эрхийн талаарх олон улсын эрх зүй, хэм хэмжээг мөрдсөн үед л Засгийн газар нийтийн хэрэгцээнд зориулж газрыг нөхөх олговор олгосны үндсэн дээр эргүүлэн авах эрхтэй. Өөрөөр хэлбэл, хүний эрхийн талаарх олон улсын хэм хэмжээг дагаж мөрдөх нь шилжилт хөдөлгөөнд хүргэдэг хөгжил, шинэчлэлийн төслийг хориглож байгаа хэрэг бус харин уг төсөлд тодорхой нөхцөл, үйл ажиллагааны хязгаар тавьдаг гэсэн үг юм. Үүнийг хангаагүй нүүлгэн шилжүүлэлтийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд “албадан нүүлгэх” гэж нэрлэдэг.

---

<sup>1</sup> Маяар Бенуа, *Олон улсын эрх зүйн дагуу Монгол Улсын дотоодын шилжин суурьшигчдын эрх: Цаг уур, Дотоод болон Худалдааны үүрэг, хариуцлага*, Зүүн Ази болон Олон улсын хууль сэтгүүл, 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр, <http://www.theglobeandmail.com/news/world/the-globe-in-mongolia-why-a-herding-culture-is-dyingout/article29791679/>

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “төр...улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно” гэж заасан. Хувийн өмчийг хууль бусаар хураан авахыг хориглох ба төр нийтийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийг дайчлан авбал тус хуулийн 16 дугаар зүйлд “нөхөх олговор, үнийг төлнө” гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн газар Улаанбаатар хотын хүн амын гэнэтийн, төлөвлөгдөөгүй өсөлт, аюулын харанга дэлдэж буй орчны бохирдлын түвшин зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр 2013 онд “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” (Ерөнхий төлөвлөгөө)-ыг баталжээ. Тус төлөвлөгөөний гол хэсэг болох гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл нь 8 дүүргийн 24 байршлын 75 хэсэгчилсэн талбайд ойролцоогоор 1500 га газар, 16109 нэгж талбарыг хамарч байна. Энэ нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн 14-15 %, хүн амын 9% гэсэн үг.<sup>2</sup> Дахин төлөвлөх хөтөлбөрийн бас нэг төсөл нь ашиглалтын шаардлага хангахгүй өөрөөр хэлбэл эдэлгээний хугацаа нь дуусч, чанаргүй болсон нийтийн зориулалттай орон сууцыг буулгаж, дахин барих төсөл юм.

Дахин төлөвлөлтийн хөтөлбөрийг нийслэлийн Засаг даргын Тамгын газар удирдаж, нийслэлийн Захирагчийн ажлын албаны харьяа төрийн байгууллагууд хэрэгжүүлж, Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналт тавьж байна. Нийслэлийн удирдлагууд гэр хороолол, шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг дахин төлөвлөх, барилгажуулах ажлыг гүйцэтгэх хувийн барилгын компанийг сонгон шалгаруулдаг. Хувийн компаниуд иргэдээс газрыг худалдаж авах, барилгын ажлын санхүүжилтийг хариуцах үүрэгтэй. Барилга, хот байгуулалтын яам (цаашид БХБЯ гэх) дахин төлөвлөлтийн үйл явц хууль, журмын дагуу явагдаж буй эсэхэд үндэсний хэмжээнд хяналт тавьж ажилладаг.

## СУДАЛГААНЫ ДҮН, ЗӨВЛӨМЖ

Эмнести Интернэшнлийн судалгааны багийнхны уулзсан олон оршин суугч дахин төлөвлөлтийн төслийг маш их дэмжиж хүлээн авснаа ярьсан юм. Гэвч тодорхой, шаардлага хангасан төрийн зохицуулалт, үр дүнтэй санал солилцох явц байхгүй, хяналт тавиагүй нь дахин төлөвлөлтөд хамрагдаж буй иргэдийн эрх ялангуяа шаардлагад нийцсэн орон байртай байх эрх зөрчигдөхөд хүргэсэн гэж Эмнести Интернэшнл үзэж байна. Хууль, дүрэм журам нь хүний эрхийн талаарх олон улсын эрх зүй, хэм хэмжээний дагуу Монгол Улсын хүлээсэн үүрэгтэй нийцэхгүй байгаа бөгөөд энэ нь олон оршин суугчийг орон гэрийнх нь асуудал яаж шийдэгдэхийг мэдэхгүй хүлээх эрсдэлд оруулж байна.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн боловч холбогдох эрх зүй, бодлогууд хожимдон гарч байна. Иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах ажлыг Нийслэл 2004 онд эхэлсэн

---

<sup>2</sup> Ардчилал сонин, М.Энхбаатар: Гэр хорооллыг барилгажуулах нь маш хэмжээний бүтээн байгуулалт гэдгийг ойлгох хэрэгтэй, 2015 оны 8 дугаар сарын 21-ний өдөр, дугаар 136/2259; Өдрийн сонин, Хотын дарга Э.Бат-Үүл гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг танилцуулав, 2016 оны 3 дугаар сарын 24-ний өдөр, хуудас 1, 5, Эмнести Интернэшнлийн архивт байгаа.



боловч, Улсын Их Хуралдөнгөж 2008 онд Хот байгуулалтын тухай хуулийг<sup>3</sup>, мөн гол хууль болох Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг<sup>4</sup> 2015 оны 6 дугаар сард баталжээ. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам боловсруулах үүрэгтэй БХБЯ-ны ажлын хэсэг 2015 оны 10 дугаар сард байгуулагдан дотоодын хууль, журмуудын зөрүүтэй, учир дутагдалтай байдлыг уг хууль болон хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээнд бүрэн нийцүүлэх хүртэл нэлээдгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Улаанбаатар хотод 2015 оны 9 дүгээр сараас 2016 оны 8 дугаар сарын хооронд Эмнести Интернэшнлээс хийсэн судалгааны ажлын дүгнэлтийг энэ тайланд орууллаа. Судалгаа нь Улаанбаатар хотын хүн амын олонхид шууд нөлөөлөх гэр хорооллын болон шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг дахин төлөвлөхтэй холбоотой үйл явцыг судалсан бөгөөд үүнд хамрагдаж буй иргэдийн эрхийг одоогийн хүчин төгөлдөр хууль дүрэм, бодлогын орчин хамгаалж чадаж буй эсэхийг үнэлсэн юм.

Монгол Улсын эрх баригчид БХБЯ-ны ажлын хэсгээс боловсруулсан нэмэлт, өөрчлөлт оруулж буй бүх хууль, дүрэм журам нь хүний эрхийн талаарх олон улсын эрх зүй, хэм хэмжээ болоод дотоодын бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг баталгаажуулах хэрэгтэй байна. Хууль, дүрэм, журмын зөрүүтэй байдлыг арилгаж, дахин төлөвлөлтөд өртөж буй иргэдийн эрхийг хангасан байдлаар шийдвэрлэвэл дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа, түүнд хамрагдаж буй хувь хүн, олон нийтийн эрхийн тодорхой бус байдал алга болно. Хууль эрх зүйн бусад актад, журамд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг олон нийтэд тодорхой мэдээлдэг байх ёстой.

Эмнести Интернэшнл дараах гол зөрчил, дутагдлыг олж тогтоосон болно. Үүнд:

- Хууль болон бодлогын баримт бичигт оршин суугаа газар, орон байраа хууль ёсоор өмчилж, эзэмшдэггүй иргэдийн дахин төлөвлөлтийн асуудлаарх зөвлөлдөх үйл ажиллагаанд оролцох эрхийг хүлээн зөвшөөрөөгүй байна;
- Албадан нүүлгэх болон орон гэргүй болох эрсдэлээс хамгаалсан арга хэмжээ учир дутагдалтай хэрэгжиж байна;
- Засгийн газрын агентлагууд, хувийн барилгын компаниуд мэдээлэл, тодруулга дутмаг өгдгөөс болж нүүлгэн шилжүүлэлт сайн дурын үндсэн дээр явагдах уу эсвэл заавал нүүх ёстой юу гэдэг талаар оршин суугчид ихэнхдээ буруу мэдээлэлтэй эсвэл ойлголтгүй байна;
- Эрх зүйн болон бодлогын орчинд ойр ойрхон оруулж буй өөрчлөлтүүдөөс үүдэн дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа, иргэдийн эрх тодорхойгүй болж, шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх зөрчигдөх эрсдэлд байна;
- Хөндөгдсөн эрхийг сэргээх талаар хууль, журам, бодлого нь ойлгомжгүй, дахин төлөвлөлтөд өртөн хохирсон иргэдэд гомдол гаргах, маргаан шийдвэрлүүлэх сонголтыг тодорхой зааж өгөөгүй байна.

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурал Хот байгуулалтын тухай хуулийг 2008 оны 5 дугаар сард баталсан бөгөөд 2015 оны 2, 6, 11 дүгээр сард нэмэлт, өөрчлөлт оруулсан; албан бус англи орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>4</sup> Монгол Улсын Их Хурал Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг 2015 оны 6 дугаар сарын 26-нд баталсан; албан бус англи орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, бодлогын баримт бичгүүдэд албан ёсны өмчлөлийн баримт бичиггүй хүмүүсийг орхигдуулсан нь хамгийн том алдаа юм. Оршин суугаа газар, орон байраа хууль ёсоор өмчилж, эзэмшдэггүй дахин төлөвлөлтөд хамрагдсан газрын иргэд аливаа зөвлөлдөх болон төслийн үйл ажиллагаанд оролцох боломжгүй байна. Газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээ нь хууль ёсны баримт бичиг юм. Өмчлөгч, эзэмшигч бус иргэн гэдэгт ихэвчлэн тухайн өмчлөгч, эзэмшигчийн газар дээр өөрийн байшин эсвэл гэрт амьдардаг төрөл садан, үр хүүхэд, эсвэл байшин түрээслэгчид хамаарч байна. Газар өмчлөх, эзэмших гэрчилгээгүй боловч тухайн газартаа амьдарсаар ирсэн иргэд Монгол Улсын хууль, тогтоомж, бодлогын дагуу нөхөн олговор авах, хөндөгдсөн эрхээ сэргээлгэх, зөвлөлдөх эрхийг эдлэж чадахгүй байна.

Газар өмчлөх, эзэмших эрх нь хууль ёсоор үүсээгүй иргэдийг дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцох ямар ч эрхгүй үлдээснээр хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээсэн үүргээ Монгол Улс зөрчиж байна. Дахин төлөвлөлтөд хамрагдсан бүх иргэн, тэднийг төлөөлөн ажиллаж буй бусад этгээд дахин төлөвлөлтийн төслийн бүх үе шатанд бүрэн оролцох, зөвлөлдөх боломжоор хангагдах ёстой. Тухайлбал, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан газар өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүрэгт наад зах нь газар өмчлөх, эзэмших гэрчилгээгүй оршин суугчдын эрхийг тусгах, тухайн газарт оршин сууж буй иргэдийг мэдээллээр хангаж, тэдэнтэй зөвлөлдөх тухай нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Албадан нүүлгэлтээс хамгаалсан хамгаалалт байхгүйгээс дахин төлөвлөлтөд өртөж буй иргэдэд их бага хэмжээгээр орон гэргүй болох эрсдэл тулгарч байна. Газар өмчилдөггүй, эзэмшдэггүй, ялангуяа түрээсийн гэрээгүй иргэдийг нүүлгэхээс өмнө мэдэгдэл өгөх эсвэл нүүлгэснээр хэн нэгнийг орон гэргүй болгохоос сэргийлсэн процедурын хамгаалалт байхгүй байна. Хувийн барилгын компанитай нөхөн олговор авахаар тохиролцсон газар өмчлөгч, эзэмшигч нь хуулийн хүрээнд арай дээр хамгаалагдсан боловч хэрэв тухайн газарт үйл ажиллагаа явуулж буй барилгын компани санхүүгийн хүндрэлд орох, барилгаа барьж чадахгүйд хүрэх, нөхөн олговроо өгч чадахгүй болох, эсвэл бусад шалтгаанаар гэрээний нөхцлөө зөрчвөл бас л хохирч үлдэхээр байна.

Улаанбаатар хотын дахин төлөвлөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, дахин суурьшуулах талаар мэдээлэл хомс байгаа нь олон улсын бодитоор зөвлөлдөх хэм хэмжээтэй нийцэхгүй байна. Дахин төлөвлөлтийн талаарх хууль, эрх зүйн бусад баримт бичигт зөвлөлдөх болон олон нийтийн оролцоог хангахыг үндсэн зарчим гэж хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэвч бодит байдал Эмнести Интернэшнлийн хийсэн судалгаанаас харахад холбогдох мэдээлэл ихэнхдээ олон нийтэд нээлттэй бус, хүртээмжтэй бус байжээ.

Оршин суугчидтай бодитоор зөвлөлдөхгүй байгаа нь тэд санал болгож буй дахин төлөвлөлтийн төсөл, үнийн саналаас татгалзаж болох эсэхэд төөрөгдөл үүсгэдэг ажээ. Эмнести Интернэшнлийн ярилцсан оршин суугчдын хоёр түр зөвлөлийн<sup>5</sup> гишүүд дахин төлөвлөлтийн хөтөлбөрийг Засгийн газар санаачилсан учир өөрсдөд нь

---

<sup>5</sup> Оршин суугчдын түр зөвлөл нь тухайн газар нутгийн газар өмчлөгч, эзэмшигчид өөрсдийн ашиг, сонирхолоо төлөөлүүлэхээр байгуулсан төлөөллийн байгууллага юм.

сонголт байхгүй, тиймээс газар дээр нь дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн төлөвлөгөө хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй барилгын компанитай тохиролцон гэрээ хийх л ёстой гэсэн ойлголттой байдаг тухайгаа хэлж байсан.

Зөвлөлдөх нь хэдийгээр үйл явцыг удаашруулж, зардал ихтэй мэт байх боловч, урт хугацаанд төслийг өртөг багатай байдлаар хэрэгжүүлэх ялангуяа, ажил эрхлэх, хоол хүнс, сургууль, эрүүл мэндийн үйлчилгээгээ алдах зэрэг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой амьжиргааны нуугдмал зардлыг олж тогтоохын зэрэгцээ тэгш бус байдал, нийгмийн зөрчил болон ялгаварлалыг багасгаж чаддаг.<sup>6</sup>

Хүн амынхаа шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хамгаалахын тулд Монгол Улсын Засгийн газар энэ эрхийг зөрчих аливаа үйлдлээс зайлсхийх, зогсоохоос гадна, уг эрхийг хашаа, байр түрээслүүлэгч, хувийн барилгын компани зэрэг гуравдагч этгээд зөрчихөөс иргэдээ хамгаалах ёстой юм. Ийм зөрчил гарсан тохиолдолд, холбогдох төрийн байгууллага зөрчлийг цааш даамжрахаас сэргийлэх арга хэмжээг авч, эрх нь зөрчигдсөн хүмүүст хуулийн дагуу хохирлоо барагдуулах, гомдлоо шийдвэрлүүлэх боломжийг баталгаажуулж өгөх ёстой.

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРООНЫ ЗАРИМ ОРШИН СУУГЧИД ОРОН ГЭРГҮЙ БОЛЖЭЭ

**Улаанбаатар хотын төв хэсэг болох Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороонд орших ашиглалтын шаардлага хангахгүй болж хуучирсан 3 дугаар байраар жишээ авч дахин төлөвлөлтийн үйл явцыг буруу хэрэгжүүлснээр оршин суугч иргэдийн эрх хэрхэн зөрчигдсөн талаарх баримтыг хүргэе.**

Байрыг нь буулгаж, шинэ байранд оруулах саналыг хувийн компани 3 дугаар байрны иргэдэд 2015 оны эхээр тавьжээ. Боловсон бие засах газар, цэвэр усны шугамгүй 3 дугаар байрныоршин суугчдад энэ нь их л боломжийн санагджээ. 2015 оны 4-7 дугаар сарын хооронд 3 дугаар байрны 28 өрх өнөөх компанитай нөхөн олговор авах гэрээ байгуулсан байна. Компани барилга баригдаж дуустал нэг жил байр түрээслэх мөнгө олгожээ. Урьд нь хувийн компаниуд ижил төрлийн санал тавин амлаж байсан ч ажил болсон зүйлгүй тул байрны зарим айл тус компанид итгээгүй бөгөөд тавьсан саналыг нь хүлээж аваагүй байна. Компани гэрээ хийсэн айлуудыг өөрсдийн саналаар нүүж байгаагаа харуулах, мөн бусад айлыг нүүлгэхийн тулд байрныхаа цонх, хаалгаа авч хаяхыг шаардсан байна. Хэд хэдэн айл шаардсан ёсоор хаалга цонхоо авсны дараагаар уг байрны паар болон төвийн дулаанд холболттой халаалтын шугам хоолой, барилгын материалуудыг тонож, хог хаях зэргээр улам сүйтгэжээ. Нийслэлийн засаг захиргаанаас оршин суугчидтай гэрээ хийж, барилгын ажлыг явуулах гээд байгаа өнөөх компани нь тэр хавийн газар нутагт барилга барих зөвшөөрөлтэй компани биш болох тухай мэдэгдлийг оршин суугчдад 2015 оны 4 дүгээр сарын 22-нд явуулсан байна. Гэвч, 2016 оны 3-5 дугаар сард Эмнести Интернэшнл оршин суугчидтай ярилцах үед тэдний зарим нь уг мэдэгдэлийг мэдээгүй, эсвэл гэрээгээ байгуулах үедээ өнөөх компани зөвшөөрөлгүй гэдгийг мэдсэн гэж хэлж байлаа.

<sup>6</sup> Эмнести Интернэшнл, Үүргээ мэд: Албадан нүүлгэлтээс урьдчилан сэргийлэх гарын авлага (Индекс: АСТ 35/009/2012): [www.amnesty.org/en/documents/document/?indexNumber=ACT35/009/2012&language=en](http://www.amnesty.org/en/documents/document/?indexNumber=ACT35/009/2012&language=en)

Жил өнгөрсөн ч барилгын ажил хийгдээгүй бөгөөд иргэдэд олгосон түрээсийн мөнгө дуусчээ. Түрээсийн мөнгөгүй болсон иргэд хамаатан садныдаа очиж амьдрах, өөрийн мөнгөөр түрээсээ төлөх, эсвэл хуучин 3 дугаар байрандаа нүүж очих гэсэн сонголт хийх болжээ. Зарим айлын хувьдхалаалтгүй, цонх, хаалгагүй байр нь хүн амьдрах боломжгүй тул 3 дугаар байр руу нүүж очих боломжгүй байжээ.

Компанитай гэрээ хийгээгүй айлуудаас төвийн халаалтгүй байрандаа 2015 онд өвөлжсөн таван өрхийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүн, бага насны хүүхдүүдтэй айл байв. Ерөнхийдөө, Улаанбаатар хотод өвөлдөө -30°C хэм хүрч хүйтэрдэг. Харин бусад айл нь хүн амьдрах боломжгүй байрнаасаа нүүж, хамаатан садныдаа эсвэл өөрсдийн зардлаар хаа нэгтээ түрээслэж өвлийг өнгөрүүлжээ. Бусдын байранд түрээс төлж суухад хэтэрхий үнэтэй байсан тул 2016 оны хавар таван айл байрандаа эргэж ирсэн байна.

Эхэндээ Засгийн газар хариуцлагаа хүлээхээс татгалзаж, оршин суугчид гурван талт гэрээ (орон сууц эзэмшигч, компани болон нийслэлийн Засаг даргын хооронд нүүлгэн шилжүүлэлтийн нөхцөл, нөхөн олговрыг зөвшилцөж тохирсон гэрээ) байгуулаагүй учраас үйл явцад оролцох, маргааныг шийдвэрлэх баталгаа гаргахгүй гэжээ. Эмнести Интернэшнл уг асуудлаар 2016 оны 3 дугаар сард яаралтай үйл ажиллагаа зарлаж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргатай уулзан 3 дугаар байрны оршин суугчдыг яаралтай, шаардлагад нийцсэн орон байраар хангахыг уриалсан ба 6 дугаар сарын 24-нд нийслэлийн Засаг дарга тухайн үед 3 дугаар байранд амьдарч байсан 10 өрхийг орон байраар хангах захирамж гаргасан байна. Гэвч 6 дугаар сарын 29-ний өдрийн сонгуулийн үр дүнгээр Засаг дарга болон эрх баригч нам солигдсоноор асуудал ахиад гацаанд оржээ<sup>7</sup>.

## АРГА ЗҮЙ

Эмнести Интернэшнл 2015 оны 9 дүгээр сараас 2016 оны 8 дугаар сарын хооронд Улаанбаатар хотод судалгаа хийсэн. Энэ хугацаанд Эмнести Интернэшнл Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК) болон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, байгаль орчин, хөгжлийн төлөөх ТББ, уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй дотоодын шилжилт хөдөлгөөний талаар анхаарч ажилладаг ТББ зэрэг олон байгууллагатай уулзсан. Түүнчлэн, Эмнести Интернэшнл Монгол Улсын Газрын тухай хууль, хот, суурин газрын хөгжлийн асуудлаар мэргэшсэн хуульчид, эрдэмтэн судлаачид; Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөллийн байгууллагын төлөөлөл; Баянзүрх дүүргийн оршин суугчдын хоёр түр зөвлөлийн төлөөлөл; Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн дахин төлөвлөлтөд өртсөн 28 иргэн, өрх; Улаанбаатар хотын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлж буй барилгын гурван компанитай уулзсан. Ярилцлага өгсөн хүмүүсийн нэрийг тайланд дурдаагүй нь хувийн компаниудтай тохиролцож буй хэлэлцээнд нь сөрөг үр дагавар дагуулахаас болгоомжилсон хэрэг болно.

Эмнести Интернэшнл 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс 22-ны хооронд үндэсний болон орон нутгийн засаг захиргааны холбогдох олон байгууллагатай уулзаж ярилцсан юм. Үндэсний түвшинд БХБЯ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, УИХ-ын

---

<sup>7</sup> СБД-ийн 10 дугаар хорооны 3 дугаар байранд амьдарч байсан 10 өрх 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдөр түр орон байраар хангагдсан гэж уг байрны оршин суугчид 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Эмнести Интернэшнлд мэдээлсэн.

Өргөдлийн байнгын хороотой уулзсан. Харин орон нутгийн түвшинд Гэр Хорооллын Хөгжлийн Газар (цаашид ГХХГ гэх), Нийслэлийн Хот байгуулалт, Хөрөнгө оруулалт хариуцсан орлогч дарга, Нийслэлийн Ерөнхий Төлөвлөгөөний Газар (цаашид НЕТГ гэх), Сүхбаатар дүүргийн Засаг дарга нартай уулзалт хийсэн. Эмнести Интернэшнл нэмэлт мэдээлэл авахаар БХБЯ, ГХХГ-т албан хүсэлт гаргасан бөгөөд БХБЯ-аас хариу ирүүлж, ГХХГ-аас хариу өгөөгүй болно. Эмнести Интернэшнл судалгааныхаа дүгнэлтийн хураангуйг БХБЯ, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2016 оны 8 дугаар сард хүргүүлж, БХБЯ болон НЕТГ-аас ирүүлсэн тодотгол, нэмэлт мэдээллийг тайландаа тусгасан болно. Түүнчлэн, Эмнести Интернэшнл улс, нийслэлийн төрийн байгууллага, агентлагуудад барилгажуулах, хот дахин төлөвлөх талаар зөвлөгөө, техникийн тусламж үзүүлсээр ирсэн Азийн хөгжлийн банк (АХБ), Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын нутагшил, Суурьшлын хөтөлбөр (НҮБ-Хабитат)-тэй уулзаж ярилцсан.

# 1. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХ: ДОТООДЫН БОЛОН ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

## 1.1 МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрсөн боловч шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийн талаар тодорхой дурдаагүй байна.

Газар өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж баталгаажуулжээ. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт төр “...улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно” гэж заасан. Түүнчлэн, тус хуулийн 16 дугаар зүйлд “хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Хэрэв, төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж заасан байна.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй” гэж иргэдийн маргаан, гомдлоо шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан бөгөөд “төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж хуульчилжээ. Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн нь “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах” эрхтэй ба нөхөн төлбөр авах зэрэг бусад эрхийг хуульчилж өгсөн байна.

Цаашлаад, Газрын тухай хуулиас бусад одоо хэрэгжиж буй дахин төлөвлөлтийн төсөлтэй холбоотой үндэсний бүх хуульд “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэсэн заалт байдаг. Түүнчлэн, Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 болон 10.3 дахь хэсэгт “олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж”, “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн

орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” хэмээн тус тус заасан байна.

## 1.2 ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХЭМ ХЭМЖЭЭ

Монгол Улсын Засгийн газар нэгдэн орсон хүний эрхийн талаарх олон улсын гэрээний дагуу шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэгтэй.<sup>8</sup> Хүний эрхийн талаарх олон улсын гэрээнд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (цаашид ЭЗНСЭОУП гэх) ордог бөгөөд эрүүл мэнд, боловсрол, ус, эрүүл ахуй, орон байраар хангагдах эрх зэрэг бусад олон эрхийг баталгаажуулсан байдаг. ЭЗНСЭОУП-ын 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг баталгаажуулснаар энэ эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх нь үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, бүх төрийн байгууллагын үүрэг болно.

ЭЗНСЭОУП-ын хэрэгжилтийг хангах удирдан чиглүүлэх үүрэгтэй шинжээчдийн байгууллага болох НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн (ЭЗНСЭ)-ийн Хорооноос шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хэрэгжүүлэх төрийн үүргийг тайлбарласан байдаг.<sup>9</sup> ЭЗНСЭ-ийн Хорооноос Засгийн газар нь шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хүндэтгэх ёстой бөгөөд албадан нүүлгэхээс зайлсхийх, газрын эзэн, хувийн өмчит барилгын компани гэх мэт гуравдагч этгээд хүний эрхийг зөрчихөөс хамгаалах, шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн, захиргааны, төсвийн, шүүхийн, соён гэгээрүүлэх гэх мэт олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой гэж заажээ. Засгийн газар хүн бүрийг наад захын тав тухыг хангасан орон байраар хангах асуудлыг нэн тэргүүний зорилгоо болгох ёстой бөгөөд төсөв хөрөнгийг хуваарилахдаа эмзэг бүлгийн хүн амыг нэн тэргүүнд орон байраар хангах хөтөлбөрийг санхүүжүүлэх ёстой. Түүнчлэн, ЭЗНСЭ-ийн Хороо нь хүмүүст өөрсдийнх сайн сайхан байдлыг хөндсөн асуудлуудад оролцож, санал бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх боломжийг олгож, хэрэв аль нэг байдлаар энэ эрх зөрчигдсөн тохиолдолд гомдлыг нь барагдуулах үр дүнтэй аргыг санал болгох хэрэгтэй гэж төрийн байгууллагуудад уриалжээ.<sup>10</sup>

ЭЗНСЭ-ийн Хорооны Ерөнхий зөвлөмж 7-д нүүлгэн шилжүүлэлт зайлшгүй гэж үзсэн үед үүнийг олон улсын эрх зүйн зарчим, эрх зүйн зайлшгүй, шударга процесс (due process)-ын шаардлагыг чанд сахин хэрэгжүүлнэ гэж онцлон тэмдэглэсэн байдаг.<sup>11</sup> Хүний эрхийн талаарх олон улсын хэм хэмжээнд зааснаар нүүлгэн шилжүүлэх гэж буй газар нь хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон орон байрны зохистой байх шаардлагад нийцсэн байх ёстой. ЭЗНСЭОУП-ын 11 дүгээр

---

<sup>8</sup> Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-нд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 11/1/ дүгээр зүйл, 1990 оны 7 дугаар сарын 5-нд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 27/3/ дугаар зүйл, 1969 оны 8 дугаар сарын 6-нд Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Олон улсын конвенцийн 5/e/iii дугаар зүйл, 1974 оны 11 дүгээр сарын 18-нд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 17 дугаар зүйлд тус тус нэгдэн оржээ.

<sup>9</sup> НҮБ-ын ЭЗНСЭ-ийн Хороо, Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх, Ерөнхий зөвлөмж 4 ба 7.

<sup>10</sup> НҮБ-ын ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий зөвлөмж 4-ийн 9 дүгээр зүйл, Ерөнхий зөвлөмж 7-ийн 13 дугаар зүйл.

<sup>11</sup> НҮБ-ын ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий зөвлөмж 7-ийн 14 дүгээр зүйл.

зүйлийн 1 дэх хэсэгт тухайн орон байр шаардлагад нийцсэн орон байр мөн эсэхийг эзэмшлийн эрх зүйн халдашгүй байдал; үйлчилгээ, материал, дэд бүтцийн хүртээмж; байрлал; хүн оршин суухад зохистой байх; худалдан авч болохуйц байх; хүртээмжтэй байх зэрэг хүчин зүйлийг харгалзаж үзнэ гэж ЭЗНСЭ-ийн Хороо тодорхойлжээ.<sup>12</sup>

Засгийн газруудад шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангах, хэрэгжүүлэх талаар мэдээлэх, зөвлөх, техникийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй НҮБ-ын шаардлагад нийцсэн орон байрны асуудлаарх Тусгай илтгэгч 2007 онд Хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамжийг гаргасан. Уг удирдамжид нүүлгэн шилжүүлэлтийн талаарх мөрдөж буй одоогийн хэм хэмжээ, эрх зүйн системийг тусгасан<sup>13</sup> ба хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн дагуу нүүлгэлтийн өмнө, үед, дараа нь авах арга хэмжээг алхам бүрээр нарийвчлан заасан байдаг. Удирдамжид зааснаар нүүлгэлт нь:

- Хуулийн дагуу;
- Хүний эрхийн талаарх олон улсын тухайн хуулийн дагуу хийгдэх;
- Зөвхөн нийтлэг сайн сайхны төлөө хийх;
- Үндэслэлтэй, хэм хэмжээтэй;
- Шударга, бүтэн нөхөн олговор, нөхөн сэргээх ажил хийхээр зохицуулсан;
- Энэхүү удирдамжийн дагуу хийгдэх ёстой гэж заажээ.<sup>14</sup>

Хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх бүх боломжийг судалж үзсэн болон зохих эрх зүйн хамгаалалт авсны дараа л нүүлгэн шилжүүлэлт хийх ёстой гэж заасан. Ийм хамгаалах арга хэмжээнд:

- Эрх нь хөндөгдсөн хүмүүстэй бодитоор зөвлөлдөх, санал бодлоо илэрхийлэх боломжоор хангах;
- Нүүлгэн шилжүүлэлт болохоос хангалттай хугацааны өмнө өртөж буй хүмүүст мэдээлэх;
- Нүүлгэн шилжүүлэлтийн тухай мэдээлэл, тухайн газар, байшинг ямар зориулалтаар ашиглах тухай мэдээллийг хангалттай цаг хугацааны өмнө өртөж буй иргэдэд мэдээлэх;
- Нүүлгэн шилжүүлэлтийн үед төрийн албан хаагчид эсвэл төлөөллүүд нь газар дээр нь ажиллах;

---

<sup>12</sup> НҮБ-ын ЭЗНСЭ-ийн, Ерөнхий зөвлөмж 4-ийн 8 дугаар зүйл.

<sup>13</sup> НҮБ-ын Хөгжилд суурилсан нүүлгэлт, шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамж, НҮБ-ын баримт бичгийн Хавсралт 1, A/HRC/4/18, 2007; [www.ohchr.org/Documents/Issues/Housing/Guidelines\\_en.pdf](http://www.ohchr.org/Documents/Issues/Housing/Guidelines_en.pdf)

<sup>14</sup> НҮБ-ын Хөгжилд суурилсан нүүлгэлт, шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамж, НҮБ-ын баримт бичгийн Хавсралт 1, A/HRC/4/18, 2007; [www.ohchr.org/Documents/Issues/Housing/Guidelines\\_en.pdf](http://www.ohchr.org/Documents/Issues/Housing/Guidelines_en.pdf)



- Нүүлгэн шилжүүлэлт хийж буй хүн бүр таних тэмдэгтэй байх;
- Нүүлгэн шилжүүлэлтэд өртөгчийн зөвшөөрөлгүй л бол нүүлгэлтийг цаг уурын таагүй нөхцөл, шөнийн цагаар хийхгүй байх;
- Хуулийн дагуу гомдол гаргах эрхийг хангах;
- Шүүхээр гомдлоо шийдвэрлүүлэх хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх;

Нүүлгэн шилжүүлэлтээс үүдэн хэн ч орон гэргүй болох эсвэл хүний эрхийн бусад зөрчилд өртөх ёсгүй гэдгийг Засгийн газар баталгаажуулах ёстой. Нүүлгэлтэд өртөж буй иргэдэд шаардлагад нийцсэн өөр орон байр, бүх хохирлыг нь барагдуулах нөхөн олговрыг нүүлгэн шилжүүлэхээс өмнө олгох ёстой.<sup>15</sup> Хүчээр хийж буй нүүлгэн шилжүүлэлт бүрийг албадан нүүлгэлт гэж үздэггүй. Хэрэв хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээнд заасан хуулийн хамгаалалтыг гүйцэтгэсэн бол, мөн хэрэглэсэн хүч нь шалтгаантай, тэнцвэртэй бол албадан нүүлгэлтийг хориглосон заалтыг зөрчөөгүй гэсэн үг юм.

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 17 дугаар зүйлд хувь хүн, гэр бүлийн амьдрал, орон байранд хөндлөнгөөс дур мэдэн хууль бусаар оролцох, халдахаас хамгаалагдах эрхийг баталгаажуулжээ. Пактын хэрэгжилтийг хянах Хүний эрхийн хороо албадан нүүлгэх нь тус Пактын 17 дугаар зүйлийг зөрчдөг гэж дүгнэсэн.<sup>16</sup> Хүний эрхийн талаарх олон улсын эрх зүй, хэм хэмжээний дагуу одоо амьдран суугаа орон байр, газартаа хууль ёсны эзэмшлийн эрхтэй эсэхээс үл хамааран хүн бүр албадан нүүлгэхээс хамгаалуулах эрхтэй. Тиймээс өмчлөл, эзэмшлийн албан ёсны баримт бичиггүй хүмүүс ч гэсэн албадан нүүлгэгдэхээс хамгаалагдах ёстой.

Хэдийгээр Монгол Улс олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүлээх үүрэг нь тодорхой ч дахин төлөвлөлтийн хөтөлбөрт хамрагдсан иргэд албадан нүүлгэлтэд өртөх эрсдэлтэй байна. Үндэсний эрх зүйн болон бодлогын баримт бичгүүд нь хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээнд заасан шаардлагад нийцсэн хамгаалалт болж чадахгүй байна. Жишээ нь, уг баримт бичигт нийгмийн бүх давхаргын хүмүүсийг хамруулаагүй бөгөөд орон байр эсвэл газар эзэмшлийн эрх зүйн халдашгүй байдлын баталгаагүй хүмүүс албадан нүүлгэлтэд өртөх, орон байргүй болох эрсдэлээс хамгаалагдаж чадахгүй байна.

ЭЗНСЭ-ийн Хороо эзэмшлийн эрх зүйн халдашгүй байдлын баталгаа нь шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийн амин чухал хэсэг гэж онцлон тэмдэглэжээ. Эзэмшил нь байр, байшин (нийтийн, хувийн)-ийн түрээс, хоршооллын байр, түрээслүүлэх, өмчлөгч байрандаа амьдрах, яаралтай үед түр хорогдох байр, албан бус суурин газар гэх мэт олон төрөл, хэлбэртэй. ЭЗНСЭ-ийн Хорооноос “ямар төрлийн эзэмшилтэйгээс үл хамааран, хүн бүр албадан нүүлгэх, дарлал болон бусад заналхийллээс хуулийн дагуу хамгаалуулсан эзэмшлийн эрх зүйн халдашгүй байдлын

---

<sup>15</sup> НҮБ-ын ЭЗНСЭ-ийн Хороо, Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх, Ерөнхий зөвлөмж 7-ийн 15, 16 дугаар зүйл.

<sup>16</sup> Хүний эрхийн Хорооны дүгнэлт, зөвлөмж: Кени улс, НҮБ-ын Хүний эрхийн Хороо CCPR/CO/83/KEN, 2005 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр, 22 дугаар догол мөрийг дараах хаягаар үзнэ үү [tinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CCPR%2fCO%2f83%2fKEN&Lang=en](http://tinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CCPR%2fCO%2f83%2fKEN&Lang=en)

баталгаатай” гэж үзсэн байдаг.<sup>17</sup>

Албадан нүүлгэлтийг хориглох тухайд ЭЗНСЭ-ийн Хороо нь “гишүүн улсууд ямар нэг нүүлгэн шилжүүлэлт хийхээс өмнө, ялангуяа олон хүнийг хамарсан нүүлгэн шилжүүлэлтийн өмнө өртөж буй бүх хүнтэй зөвлөлдөж нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, нөлөөг нь аль болох багасгах, хүч хэрэглэхгүй байх бусад боломжит аргыг судлах ёстой” гэж тэмдэглэсэн.<sup>18</sup> НҮБ-ын Хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамжид “хэрэв оролцогч талууд өгсөн хувилбартай санал нийлэхгүй бол, шүүх, тусгай шүүх эсвэл омбудсмэн гэх мэт Үндсэн хуулиар эрх үүргийг нь тогтоосон хараат бус байгууллага талуудын дунд зуучлан эвлэрүүлэх, арбитр, шүүхээр шийдвэрлэх хэрэгтэй ” гэж заасан байна”.<sup>19</sup>

ЭЗНСЭ-ийн Хороо нь нүүлгэн шилжүүлэлтэд өртөж буй хүмүүстэй бодитоор зөвлөлдөх нь албадан нүүлгэлтээс хамгаалах үндсэн арга гэж үздэг.

**“Бодитоор зөвлөлдөх”** гэдэг нь нүүлгэн шилжүүлэлтэд өртөж буй хүмүүсийн бодит оролцоог хангахын тулд бүрэн, зөв мэдээллээр цаг тухайд нь хангахыг хэлнэ. Мэдээлэл нь нүүлгэн шилжүүлэлтэд өртөж буй хүмүүст ойлгогдохуйц хэлбэр, хэлээр байх ёстой. Түүнчлэн, бодитоор зөвлөлдөх нь нүүлгэн шилжүүлэлтэд өртөгчид, тэдний гэр бүлд бодож тунгаах, хэлэлцэх, нөхөх олговор, дахин суурьших газар, нүүлгэн шилжүүлэлт зэрэг холбогдох төлөвлөгөөнд санал өгөх, засаг захиргааны байгууллагад асуудал тавих, хариу авах үйл явцыг хэлнэ.

Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс нь нийтээрээ, бие төлөөлөгчөөрөө дамжуулж, жижиг бүлэг эсвэл хувиараа бодитоор зөвлөлдөх үйл явцад оролцох боломжтой байх ёстой.

НҮБ-ын Хөгжилд суурилсан нүүлгэлт, шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамжид заахдаа:

*“Хот, хөдөөгийн төлөвлөлт, хөгжүүлэх үйл явцад өртөж болзошгүй иргэдийн оролцоотой явагдах ёстой бөгөөд үүнд дараах зүйлс: (а) үйл явцад өртөж болзошгүй бүх хүнд нүүлгэн шилжүүлэх талаар зохих мэдэгдэл өгөн санал болгож буй төлөвлөгөө, хувилбар дээрээ олон нийтийн саналыг сонсох; (б) засаг захиргаанаас газрын тухай мэдээлэл, ялангуяа эмзэг бүлгийнхнийг хамгаалах чармайлт бүхий дахин суурьшлын цогц төлөвлөгөө зэрэг холбогдох мэдээллийг урьдчилан үр дүнтэй түгээх; (в) санал болгож буй төлөвлөгөөг олон нийт хэлэлцэх, санал өгөх, эсвэл эсэргүйцлээ илэрхийлэх хангалттай хугацаа өгөх; (г) өртөж буй хүмүүст өөрсдийнх нь эрх, боломжийн талаар хууль зүйн, мэргэжлийн болон бусад зөвлөгөө өгөх боломжоор хангахыг чармайлт болон (д) өртөж буй хүмүүс, тэдний өмгөөлөгчдөд нүүлгэн шилжүүлэлтийн шийдвэрийг эсэргүйцэх, өөр санал гаргах, хэрэгцээ болон хөгжлийн нэн тэргүүний*

<sup>17</sup> НҮБ-ын ЭЗНСЭ-ийн Хороо, Ерөнхий зөвлөмж 4-ийн 8/а/ дугаар зүйл.

<sup>18</sup> НҮБ-ын ЭЗНСЭ-ийн, Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх, Ерөнхий зөвлөмж 7-ийн 13 дугаар зүйл.

<sup>19</sup> НҮБ-ын Хөгжилд суурилсан нүүлгэлт, шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамж, НҮБ-ын баримт бичгийн Хавсралт 1, А/HRC/4/18, 2007; 59 дүгээр догол мөрийг дараах хаягаар үзнэ үү [www.ohchr.org/Documents/Issues/Housing/Guidelines\\_en.pdf](http://www.ohchr.org/Documents/Issues/Housing/Guidelines_en.pdf)

зорилтуудаа илэрхийлэх боломж олгосон олон нийтийн хэлэлцүүлэг хийх” зэрэг багтана.<sup>20</sup>

Монгол Улс 2010 оны 7 дугаар сард ЭЗНСЭОУП-ын Нэмэлт протоколыг хүлээн зөвшөөрч нэгдэн орсон. Нэмэлт протоколд зааснаар ЭЗНСЭ-ийн Хороо Монгол Улсад ЭЗНСЭОУП-ыг зөрчсөн асуудлаар гомдол хүлээн авах болсон. Дотоодын гомдол барагдуулах эрх зүйн бүх шатыг хэрэглэсний дараа ЭЗНСЭ-ийн Хороонд гомдол гаргах боломжтой болдог. Өнөөдрийг хүртэл ЭЗНСЭ-ийн Хороо Монгол Улсаас гомдол хүлээж аваагүй байна.

ЭЗНСЭОУП-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 4 дэх тайланд ЭЗНСЭ-ийн Хорооноос “Оршин суугаа газар нь дахин төлөвлөлтөд орж буй иргэдийн хувьд ‘Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам’-ын дагуу албадан нүүлгэлтэд өртөх, ялангуяа газраа өмчлөх, эзэмших албан ёсны бичиг баримтгүй хүмүүст ямар нэгэн нөхөн олговор олдохгүй, нийгмийн суурь үйлчилгээтэй газар өөр орон байраар хангагдахгүй байх зэрэг сөрөг үр нөлөө гарч байгаа”-г асуудал болгон хөндсөн байна.<sup>21</sup>

Тус Хорооноос Монгол Улсын Засгийн газарт хэд хэдэн зөвлөмж хүргүүлсний дотор “иргэдийн газар, эд хөрөнгө эзэмшлийн эрх зүйн халдашгүй байдал, албадан нүүлгэлтээс хамгаалагдах, хангалттай нөхөн олговор, нийгмийн суурь үйлчилгээнд ойр газар өөр орон байраар хангагдахгүй байх зэрэг гэр хорооллын иргэдийн шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхэд сөргөөр нөлөөлөхгүй байхыг баталгаажуулахын тулд ‘Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам’-д нэмэлт, өөрчлөлт оруулж” мөн “албадан нүүлгэлтийг хориглосон үндэсний эрх зүйн хүрээ боловсруулах, үүнийг хүний эрхийн талаарх олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх хэрэгтэй” гэжээ.<sup>22</sup>

---

<sup>20</sup> НҮБ-ын Хөгжилд суурилсан нүүлгэлт, шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамжийн зарчим 37.

<sup>21</sup> НҮБ-ын ЭЗНСЭ-ийн Хороо, Монгол Улсын 4 дэх илтгэлийн талаарх дүгнэлт, зөвлөмж, 2015 оны 6 дугаар сарын 19, хуудас 7-г дараах хаягаар үзнэ үү [tbinternet.ohchr.org/\\_layouts/TreatyBodyExternal/countries.aspx?CountryCode=MNG&Lang=EN](http://tbinternet.ohchr.org/_layouts/TreatyBodyExternal/countries.aspx?CountryCode=MNG&Lang=EN)

<sup>22</sup> НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Монгол Улсын 4 дэх илтгэлийн талаархи дүгнэлт, зөвлөмж, 2015 оны 6 дугаар сарын 19, хуудас 7-г дараах хаягаар үзнэ үү [tbinternet.ohchr.org/\\_layouts/TreatyBodyExternal/countries.aspx?CountryCode=MNG&Lang=EN](http://tbinternet.ohchr.org/_layouts/TreatyBodyExternal/countries.aspx?CountryCode=MNG&Lang=EN)

## 2. УЛААНБААТАР ХОТЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ

Урьдчилан тооцоолоогүй хүн амын хурдацтай өсөлт, үүнээс үүдэн байгаль орчинд гарч буй сөрөг үр дагавар ихэссэн учраас Улаанбаатар хотыг дахин төлөвлөх хөтөлбөр боловсруулжээ. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, түүний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”(цаашид Ерөнхий төлөвлөгөө гэх)-д тусгагдсан уг хөтөлбөр орон сууцны хорооллыг дахин төлөвлөх, дэд бүтэц бий болгох, сайжруулах, гэр хорооллыг орон сууцжуулах, ашиглалтын шаардлага хангахгүй хуучны барилгыг буулган, барилгажуулах ажил багтсан байна. Дахин төлөвлөлтийн зорилго нь Монгол Улсын “иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах” явдал юм.<sup>23</sup>

Эрдэс баялгийн олборлолттой холбоотойгоор эдийн засаг хурдацтай өсөж байсан нь Улаанбаатар хотын дахин төлөвлөлтийн хөтөлбөрийг эхлүүлэхэд түлхэц болжээ. Гэвч түүхий эдийн үнэ унасан төдийгүй улс төр, эдийн засгийн оновчгүй шийдвэр, үйл ажиллагаанаас болж 2011 онд 17.3 хувийн өсөлттэй байсан эдийн засаг 2015 онд 2.3 хувь болж огцом буурсан. Азийн хөгжлийн банк (АХБ) 2016 онд эдийн засгийн өсөлт 1 хувиас доош байна гэсэн таамаг дэвшүүлсэн.<sup>24</sup> Энэ байдал нь дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хувийн хэвшлийн компаниуд дахин төлөвлөлтийн хөтөлбөрт батлагдсан барилгын ажлаа хийх, дуусгах боломжийг хаасан байна.

### 2.1 УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ОРЧНЫ БОХИРДОЛ

Монгол Улс ойролцоогоор 3 сая хүн амтай, үүний 1.3 сая нь Улаанбаатар хотод амьдарч байна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээс харахад, 2000-2010 оны хооронд Улаанбаатарын хүн ам жилд 5,4 хувиар өсөж, шилжин ирэгсдийн олонх нь гэр хороололд суурьшжээ.<sup>25</sup> Хүн амын хэт өсөлт нь хөдөө, орон нутгаас малчин гэр бүл эдийн засгийн боломж хайн, үйлчилгээнд илүү ойртохын тулд хотод шилжин ирж байгаа дотоодын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой юм. Нийслэлийн хүн ам 2020 он гэхэд 1.6 сая, 2030 онд 2.1 сая болох төлөвтэй байна.<sup>26</sup>

Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь амьдардаг гэр хороолол нь дахин төлөвлөлтийн гол зорилтот газар юм. Гэр хорооллын айл болгон үндэсний уламжлалт орон сууц болох дугуй хэлбэртэй эсгий гэрт амьдраад байдаггүй.<sup>27</sup> Гэр хороололд гэр,

<sup>23</sup> Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйл.

<sup>24</sup> АХБ, Монгол Улсын тухай вэб хуудас. Энэ хаягаар үзнэ үү: [www.adb.org/countries/mongolia/economy](http://www.adb.org/countries/mongolia/economy)

<sup>25</sup> Үндэсний статистикийн хороо, *Хүн ам, орон сууцны 2010 оны Улсын тооллогын үр дүн*. Энэ хаягаар үзнэ үү: [www.slideshare.net/Ochiro/mongolia-2010-population-census-main-findings](http://www.slideshare.net/Ochiro/mongolia-2010-population-census-main-findings)

<sup>26</sup> Монголын статистик мэдээллийн нэгдсэн сан, [www.1212.mn](http://www.1212.mn)

<sup>27</sup> Хэдийгээр гэр нь Монгол Улсад хамгийн түгээмэл хүн амьдрах орон байр болж байгаа ч, шаардлагад нийцсэн орон байр гэсэн орчин үеийн стандартыг хангахгүй байна.Түүнчлэн, дахин төлөвлөлтийн хөтөлбөрийг нийтээрээ хүлээн зөвшөөрсөн мэт харагдаж байгаа боловч, зарим

байшин (тоосго эсвэл өөр материалаар барьсан) бий. Гэр хороолол гэж гол төлөв засмал зам, дулаан, ус, ариун цэврийн байгууламж зэрэг дэд бүтэц хязгаарлагдмал газруудыг хэлдэг.<sup>28</sup> Гэр хорооллын байшин гэртэй харьцуулахад цэвэр ус дамжуулах болон бохир зайлуулах системтэй байх нь бий.<sup>29</sup> Түүнчлэн, гэр хороололд сургууль, эмнэлэг гэх мэт нийгмийн дэд бүтэц сул хөгжсөн байдаг. Хотын бусад хэсгүүдтэй харьцуулахад гэр хороололд ядуурал, ажилгүйдлийн түвшин өндөр ажээ.

Гэр хороолол нь хашаанаас бүрдэнэ. Ердийн нэг хашаанд нэг, түүнээс олон гэр, эсвэл байшин байдаг бөгөөд тухайн айлын хүү, эсвэл охины гэр бүл, хүүхдүүд гэх мэт садан төрлийн хүмүүс амьдардаг. Энэ тохиолдолд нэг хашаа олон өрх амьдрах газар болдог. Зарим нь хашаандаа бизнесийн зорилгоор үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, эсвэл гэртэй айл хөлсөөр буулгадаг байна.

Хотын хүн ам төлөвлөгөөгүй огцом өсөж, ялангуяа гэр хороолол улам тэлсэн нь байгаль орчны, тэр дундаа агаар, хөрсний бохирдол үүсгээд байна. Агаарын бохирдлын талаарх Дэлхийн банкны 2011 оны судалгаагаар Улаанбаатар хот дэлхийн агаарын чанар хамгийн муу нийслэл хотуудын нэг гэж гарсан бөгөөд агаарын бохирдлын гол шалтгаан төдийгүй хохирогч нь гэр хорооллын айл өрхүүд гэжээ.<sup>30</sup> Улаанбаатар хотын агаарын бохирдол -30 хэмтэй өвлийн сард хамгийн дээд түвшиндээ хүрдэг. Халаалтын системд холбогдоогүй гэр хорооллынхон, түүний дотор гэрт амьдардаг өрхүүд дулаан байхын тулд мод, нүүрс, ядуу өрхүүд хуучин дугуй, хуванцар гэх мэтийг түлдэг.<sup>31</sup> Агаарын бохирдлыг үүсгэж буй бусад эх сурвалж нь дулааны цахилгаан станц, уурын зуух, тээврийн хэрэгслийн утаа болж байна.<sup>32</sup>

---

хэвлэлийн нийтлэл, ТББ болон оршин суугчдын хэлж буйгаар гэр хорооллын зарим айл гэрийг нь дэд бүтэцэд холбоод өгвөл орон сууцанд орсноос гэртээ амьдрахыг илүүд үздэг гэжээ. Гардиан сэтгүүлийн 2014 оны 9 дүгээр сарын 3-ны дугаар, Питер Геогеган, Улаанбаатарын гэр хорооллын амьдрал хатуу ч Монголчууд гэрээсээ татгалзахгүй нь. [www.theguardian.com/cities/2014/sep-03/mongolia-ulanbaatar-ger-yurt-tent-city](http://www.theguardian.com/cities/2014/sep-03/mongolia-ulanbaatar-ger-yurt-tent-city)

<sup>28</sup> Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад “гэр хороолол” гэж хот, суурин газрын эдэлбэр газар дахь инженерийн болон нийгмийн дэд бүтцээр бүрэн хангагдаагүй гэр, орон сууц бүхий суурьшлыг хэлнэ гэж тодорхойлсон байна.

<sup>29</sup> Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын Хүн амын сан (НҮБХАС), хүүхдийн эрх, амьдрах чадвар, хөгжил, хамгааллын чиглэлээр ажилладаг НҮБ-ын Хүүхдийн сан нь (ЮНИСЕФ) - “Монгол Улс: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2013 – Дүгнэлтийн хураангуй,” 2014 оны 6 дугаар сар, [microdata.worldbank.org/index.php/catalog/2535/download/36784](http://microdata.worldbank.org/index.php/catalog/2535/download/36784). Улаанбаатар хотын нийт өрхийн 98,4 хувь нь цахилгааны эх үүсвэрт холбогдсон байна.

<sup>30</sup> Дэлхийн Банк, Улаанбаатар хотын агаарын чанарын шинжилгээ: эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахын тулд агаарын чанарыг дээшлүүлэх нь, Хэлэлцүүлгийн баримт бичиг, 2011 оны 12 дугаар сар, [www-wds.worldbank.org/external/default/WDSContentServer/WDS/IB/2012/01/16/000386194\\_20120116025654/Rendered/PDF/660820v10revis00Mongolia0Report0Web.pdf](http://www-wds.worldbank.org/external/default/WDSContentServer/WDS/IB/2012/01/16/000386194_20120116025654/Rendered/PDF/660820v10revis00Mongolia0Report0Web.pdf)

<sup>31</sup> Гүдзонсон, Хөдөө нутгаа орхисон Монголын малчдыг хотын гэр хороололд гачигдал дунд амьдрах тавилан угтаж байна, Олон улсын Улаан загалмайн нийгэмлэг, 2016 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр,

<sup>32</sup> Дэлхийн Банк, Улаанбаатар хотын агаарын чанарын шинжилгээ: эрүүл мэндийн эрсдэлийг бууруулахын тулд агаарын чанарыг дээшлүүлэх нь, Хэлэлцүүлгийн баримт бичиг, 2011 оны 12 сар, [www-wds.worldbank.org/external/default/WDSContentServer/WDS/IB/2012/01/16/000386194\\_20120116025654/Rendered/PDF/660820v10revis00Mongolia0Report0Web.pdf](http://www-wds.worldbank.org/external/default/WDSContentServer/WDS/IB/2012/01/16/000386194_20120116025654/Rendered/PDF/660820v10revis00Mongolia0Report0Web.pdf)

Улаанбаатар хотын хөрсний бохирдол нь тээврийн хэрэгслийн тоо, аж үйлдвэрийн хог хаягдал, гэр хорооллын нүхэн жорлонгийн тоо нэмэгдэж байгаатай холбоотой.<sup>33</sup> Гэр хорооллын гэр, байшинд амьдардаг иргэд бохир зайлуулах системд холбогдоогүй тул нүхэн жорлонд бие засах болон нийтийн бие засах газар ашигладаг байна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээс харахад улсын хэмжээнд байгаа барилга, байшингийн дөнгөж 42.4 хувь буюу тал хүрэхгүй хувь нь боловсон бие засах газартай байна.<sup>34</sup> Гэр хорооллын оршин суугчдын ихэнх нь хашаандаа нүхэн жорлонтой, эсвэл ойролцоох нийтийн бие засах газар очдог ажээ. Энэ байдал нь гепатит А, цусан суулга, сальмонеллын халдвар, суулгалт гэх мэт халдварт өвчний үүсгүүр ба эрүүл мэндэд олон эрсдэл үүсгэж байна.<sup>35</sup>

## 2.2 ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Саяхныг хүртэл Засгийн газар гэр хорооллыг түр орон байр хэмээн үзэж, усан хангамж, ариун цэвэр, халаалт гэх мэт зайлшгүй шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, төлөвлөх, хөгжүүлэх асуудлыг орхигдуулсаар ирсэн. Гэр хорооллын талаарх бодлого 2000 оноос эхлэн өөрчлөгдөн үүнийг түр болон байнгын оршин суугч амьдардаг газар гэдгийг хүлээн зөвшөөрч эхэлсэн байна.<sup>36</sup> Энэ нь Улаанбаатар хотын орчин, иргэдийн эрүүл мэндэд гэр хороолол ихээр нөлөөлөхөд хүргэсэн байна..

Монгол Улсын Их Хурал (УИХ) 2008 онд хот, суурин газар байгуулах асуудлыг зохицуулах зорилготой "Хот байгуулалтын тухай хууль"-ийг баталсан. Хуулийн дагуу хот, суурин газар бүр хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ёстой. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага" (Ерөнхий төлөвлөгөө) гэсэн нэртэй бөгөөд үүнийг 2013 онд Улаанбаатар хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, УИХ-аар баталжээ.<sup>37</sup> Гэр хорооллыг дахин төлөвлөх, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх, иргэдийн санаачилсан дахин төлөвлөлт гэсэн орон сууцжуулах гурван гол төсөл бий.<sup>38</sup>

<sup>33</sup> Б.Дөлгөөн, *Гадаах бие засах газрыг муу арчлах нь халдварт өвчний дэгдэлтийг ихэсгэх эрсдэлтэй*, Юү Би Пост сонин, 2016 оны 4 сарын 8-ны өдөр, [ubpost.mongolnews.mn/?p=19169](http://ubpost.mongolnews.mn/?p=19169)

<sup>34</sup> Үндэсний статистикийн хороо, *Хүн ам, орон сууцны 2010 оны Улсын тоологын үр дүн*, энэ хаягаар үзнэ үү, [en.ubseg.gov.mn/content/49](http://en.ubseg.gov.mn/content/49)

<sup>35</sup> Б. Дөлгөөн, *Гадаах бие засах газрыг муу арчлах нь халдварт өвчний дэгдэлтийг ихэсгэх эрсдэлтэй*, УБ Пост сонин, 2016 оны 4 сарын 8-ны өдөр, [ubpost.mongolnews.mn/?p=19169](http://ubpost.mongolnews.mn/?p=19169). Дэлхийн банкны 2013 оны судалгаагаар Улаанбаатар хотын 5 хүртэлх насны хүүхдийн 50,6 хувь нь эрүүл мэндийн байгууллага, эмчээс сүүлийн 2 долоо хоногт суулгалтын эсрэг эмчилгээ, зөвлөгөө авсан гэж гарчээ: [microdata.worldbank.org/index.php/catalog/2535](http://microdata.worldbank.org/index.php/catalog/2535)

<sup>36</sup> Эмнести Интернэшнлийн НҮБ-Хабитат байгууллагатай хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдөр.

<sup>37</sup> Гэр хорооллын хөгжлийн газар (одоогийн Гэр хорооллын дэд бүтцийн газар), *Нийслэлийн гэр хорооллын хөгжлийн газрын үйл ажиллагааны тайлан 2014 он*, хуудас 77, Эмнести Интернэшнлийн архивт албан бус орчуулга байгаа. Энэ тайланг жилд 2 удаа гаргадаг бөгөөд гэр хорооллын дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн талбайн төслүүдийн хэрэгжилтийг тайлагнадаг. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төлөвлөгөөг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (НИТХ)-ын 2013 оны 7/29, 12/43 дугаар тогтоол, 2014 оны 14/02 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

<sup>38</sup> Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухайн хуулийн дагуу дахин төлөвлөлтийн 4 дэх зорилт нь одоо байгаа орон сууцны хорооллуудыг Ерөнхий төлөвлөгөө болон дахин төлөвлөлтийн стратеги, бусад төлөвлөгөөтэй уялдуулах гэж заасан байна.

Төсөл бүрийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харъяа байгууллагууд хариуцан хэрэгжүүлж байна.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг Гэр хорооллын дэд бүтцийн газар (ГХДБГ) хариуцаж байгаа бөгөөд уг газар нь 2012 оны 12 дугаар сарын 22-нд байгуулагдсанаасаа хойш 2016 он хүртэл Гэр хорооллын хөгжлийн газар (ГХХГ) гэсэн нэртэй байлаа. ГХДБГ нь Төслийн удирдах хорооны нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэдэг бөгөөд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг хянах, удирдлагаар хангах зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны удирдлагад ажилладаг байна. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл нь 8 дүүргийн<sup>39</sup> 24 байршлын 75 хэсэгчилсэн талбайд ойролцоогоор 1500 га газарт 16109 нэгж талбарыг хамарч байна.<sup>40</sup> Энэ нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн 14-15 хувь буюу хотын хүн амын 9 хувийг хамарч байна гэсэн үг юм.<sup>41</sup> ГХДБГ-ын албан хаагчид 54 хэсэгчилсэн төсөл хэрэгжиж дууссан, 25 төсөл хэрэгжилтийн шатандаа байгаа гэж Эмнести Интернэшнлтай 2016 оны 3 дугаар сард хийсэн уулзалтын үеэр хэлсэн байна.<sup>42</sup> Гэвч, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар (НЕТГ) 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн Эмнести Интернэшнлд ирүүлсэн албан бичигтээ "2016 оны 9 дүгээр сарын байдлаар 75 хэсэгчилсэн төслөөс 44 төслийн төлөвлөгөө батлагдсан, 6 төслийн төлөвлөгөө нь батлагдаагүй, 10 газрын төсөл хэрэгжүүлэх компаний зөвшөөрлийг цуцалсан, мөн 15 газарт ажил гүйцэтгэх компани сонгон шалгаруулаагүй байгаа" гэж мэдээлсэн байна.<sup>43</sup>

Эдэлгээний хугацаа дуусч, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх төслийг НЕТГ хариуцан хэрэгжүүлж байна. 1999 онд Орон сууцны тухай хууль батлагдсан ба уг хуулийн 15<sup>1</sup> дүгээр зүйлд ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцыг ашиглахыг хориглосон байдаг.<sup>44</sup>

---

<sup>39</sup> Нийслэл Улаанбаатар хот нь 9 дүүрэгтэй, төвийн 6, захын 3 дүүрэгтэй. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүд төвийн 6, захын 2 дүүрэгт хэрэгжиж байгаа.

<sup>40</sup> Монгол Улсын 4 дэх ээлжит нэгдсэн дүгнэлт хэлэлцүүлгийн тайлантай холбоотой нэмж тодруулах асуудлын жагсаалт: Монгол Улсын хариулт, 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдөр, дэлгэрэнгүйг: [tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=E%2fC.12%2fMNG%2fQ%2e4%2fAdd.1&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=E%2fC.12%2fMNG%2fQ%2e4%2fAdd.1&Lang=en)

<sup>41</sup> Ардчилал сонин, М. Энхбаатар: Гэр хорооллыг барилгажуулах нь гэдэг нь том хэмжээний бүтээн байгуулалт гэдгийг ойлгох хэрэгтэй, 2015 оны 8 дугаар сарын 21-ний өдөр, дугаар 136/2259; Өдрийн сонин, Хотын дарга Бат-Үүл гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг танилцууллаа, 2016 оны 3 дугаар сарын 24, хуудас 1, 5, Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>42</sup> ГХДБГ-тай Эмнести Интернэшнлийн хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр.

<sup>43</sup> Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын Эмнести Интернэшнлд ирүүлсэн захидал, 2016 оны 9 дүгээр сарын 7, дугаар 09/2588, албан бус орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>44</sup> Монгол Улсын Их Хурал Орон сууцны тухай хуулийг 1999 оны 4 дүгээр сарын 22-нд баталсан, нэмэлт өөрчлөлтийг 2003 оны 2 дугаар сарын 2, 5 дугаар сарын 15, 6 дугаар сарын 18-нд, 2005 оны 1 дүгээр сарын 27-нд, 2006 оны 6 дугаар сарын 29-нд, 2011 оны 2 дугаар сарын 9, 2015 оны 1 дүгээр сарын 23, 12 дугаар сарын 4-нд тус тус хийж баталжээ.

НЕТГ одоогийн байдлаар шаардлага хангахгүй орон сууцны байрыг дахин төлөвлөх 85 төслийг хэрэгжүүлж байна.<sup>45</sup>

Иргэдийн санаачилсан газар шинэчлэн, зохион байгуулах төслийг Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл (ГХОСТ) хариуцан ажиллаж байсан. Эдгээр нь гэр хорооллын оршин суугчдын санаачлагаар газар нутгаа дахин зохион байгуулах төлөвлөгөө юм. Гэр хорооллын газрыг шинэчлэн барилгажуулах 8 төслийн төлөвлөлт байгаа ч 2016 оны 7 дугаар сарын байдлаар нэг ч төсөл хэрэгжиж эхлээгүй байна. ГХОСТ нь гэр хорооллын дахин төлөвлөлтөд хамрагдсан газрын иргэд, олон нийтийн оролцоог хангах ажил хариуцдаг байсан.

Энэ тайланд ГХДБГ болон НЕТГ-ын хариуцаж байгаа гэр хорооллыг дахин төлөвлөх болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх төслийн талаар голдуу бичсэн. Иргэдийн шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хөндөж буй дээрх хоёр төсөл нь дахин төлөвлөлтийн хөтөлбөрийн дийлэнх хэсэг болно.

## 2.3 ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН САНХҮҮЖИЛТ

Дахин төлөвлөлтийн төслүүдийн санхүүжилт нь улс, нийслэлийн төсөв, Засгийн газрын бонд, хувийн барилгын компаниудаас гарч байна. Засгийн газраас гэр хорооллын дахин төлөвлөлтөд голдуу ус, халаалт, бохир ус зайлуулах шугам, зам барих зэрэг дэд бүтэц барих мөн уг үйлчилгээнд барьсан шинэ байшингаа холбоход санхүүжилт хийдэг байна.

Хувийн өмчит компанийг Засгийн газар гэр хороолол, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх төсөлд төсөл хэрэгжүүлэгчээр сонгон шалгаруулдаг бөгөөд тэд төсөлтэй холбоотой санхүүжилтийг хариуцах үүрэгтэй байдаг.<sup>46</sup> Үүнд төслийн хугацаанд түр суурьшуулах болон нөхөн олговрын зардал багтдаг. Ерөнхийдөө, хувийн компани нь орон сууцны барилга барих үүрэгтэй ч газраа чөлөөлсөн өрхийн/иргэдийн тооноос илүүдүүлэн барьж, илүү гарсан байраа зарж зардлаа нөхөхийг зорьдог.

Эдийн засгийн уналт нь засгийн газарт ч хувийн компаниудад ч дахин төлөвлөлтийн төслийг санхүүжүүлэхэд сөргөөр нөлөөлсөөр байна. Энэ байдал гэр хороолол болон шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг дахин төлөвлөх төслүүдэд тохиолдож байна. Жишээ нь, 2015 онд Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт инженерийн бэлтгэл ажил, дэд бүтэц барихаар 5.9 тэрбум төгрөг (2.8 сая ам.доллар)-ийг Чингис бондын хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан боловч эдийн засгийн

---

<sup>45</sup> НЕТГ-ын албан хаагчидтай 2016 оны 3 дугаар сарын 21-нд Эмнести Интернэшнлийн хийсэн ярилцлага. Бүтцийн хувьд баталгаагүй болсон орон сууцанд амьдарч буй оршин суугчдыг дахин байртай болгох НЕТГ-ын хариуцдаггүй өөр төслүүд байдаг байж болох юм. Жишээ нь, хэрэв гурван талт гэрээ байхгүй бол (нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын талаар зөвшөөрсөн газар өмчлөгч/эзэмшигч, хувийн компани болон Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээ) Засгийн газар үйл явцыг баталгаажуулж, эсвэл маргаан гарсан тохиолдолд зуучлан зохицуулдаггүй гэжээ.

<sup>46</sup> Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3 дахь заалт



хүндрэлээс болоод энэ төсвийг гаргаж чадаагүй байна.<sup>47</sup>

Зарим төсөл хэрэгжүүлэгч санхүүгийн хүндрэлээс болоод төслөө зогсоосон, эсвэл эхлүүлж чадахгүй байна гэсэн үг юм. Жишээ нь, Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хорооны газар өмчлөгч, эзэмшигчид 2013 онд нутаг дэвсгэрт нь дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэхээр сонгогдсон хувийн компанитай гэрээ хийсэн боловч тухайн компанийн санхүүгийн асуудлаас болж төсөл зогсонги байдалд орсон оршин суугчид үзсэн байна.<sup>48</sup> 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр тухайн үеийн нийслэлийн Засаг дарга гэр хорооллын дахин төлөвлөлтийн барилгажилтын ажлыг 6 сар хүртэлх хугацаанд эхлүүлээгүй, үйл ажиллагааны зөрчил удаа дараа гаргасан” тул зарим хувийн компаниудын төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах захирамж гаргасан байна.<sup>49</sup>

Олон улсын хөгжлийн байгууллагууд чадавх нэмэгдүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, дахин төлөвлөлтийн төслүүдэд шууд оролцох гэх мэтээр Улаанбаатар хотыг дахин хөгжүүлэх хөтөлбөрт тодорхой үүрэг гүйцэтгэж байна. Техникийн туслалцаа, бусад талын дэмжлэг үзүүлж буй гол байгууллага нь Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), НҮБ-Хабитат болон АХБ болно.<sup>50</sup> ЖАЙКА Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад техникийн зөвлөгөө өгөх зэргээр 2007 оноос хойш өргөн хүрээтэй техникийн туслалцаа үзүүлсээр ирсэн байна.

---

<sup>47</sup> Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо, “УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд гэр хорооллын нөхцлийг сайжруулах, дахин хөгжүүлэх төслийн явцын талаар иргэдээс ирсэн гомдлыг шалгах ажлын хэсгийн тайлан”, 2015 он; албан бус англи орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>48</sup> Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хорооны нийт оршин суугчдыг төлөөлсөн Гэр хорооллын барилгажилт төслийг дэмжих Чингэлтэй Саруул оршин суугчдын хороотой Эмнести Интернэшнлийн хийсэн ярилцлага, 2015 оны 12 сарын 7-ны өдөр.

<sup>49</sup> Нийслэлийн Засаг даргын 2016 оны 6 сарын 30-ны өдрийн А/568, А/572 тоот захирамж; албан бус англи орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>50</sup> Энэ жагсаалт бүрэн биш. Дэлхийн банк, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг гэх мэт бусад олон улсын хөгжлийн байгууллагууд гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах, эсвэл гэр хорооллын барилгажилтын бусад төслүүдэд оролцож байна. АХБ нийслэл хотын удирдлагуудтай хамтарч хотын төвөөс гадагш дэд төвүүдийг байгуулах дэд бүтцийг хөгжүүлэх, хотын замын түгжрэлийг бууруулах, боломжийн үнээр орон сууцаар хангах чиглэлээр ажиллаж байна гэж Эмнести Интернэшнлд мэдээлсэн. АХБ-ны санхүүжүүлэлтээр хэрэгжиж буй дэд бүтцийг хөгжүүлэх төсөлд хамрагдаж буй газрын оршин суугчдын нүүлгэн шилжүүлэлт АХБ-ны өөрийнх нь дүрэм журмын дагуу явагддаг байна. Энэ нь тухайн газар нутгийн бүх иргэн, газар өмчлөгч, эзэмшигч бус ч бай, санал солилцох үйл явцад оролцож, нөхөн олговор авах эрхтэй гэсэн үг. Харин нийслэлийн дахин төлөвлөлтийн хөтөлбөрт хамрагдах газар нутгийн газар өмчлөгч, эзэмшигч бус иргэд зөвлөлдөх үйл явцад оролцож чаддаггүй тул үүнээс ялгаатай байна. Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг зөрчсөн, хүчээр нүүлгэх хүртэлх арга хэмжээнд хүргэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжихгүй байхад хоёр болон олон талт хандивлагчид анхаарах хэрэгтэй.

### 3. ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

Дахин төлөвлөлт нь хүмүүсийг их бага хэмжээгээр нүүлгэн шилжүүлэхэд хүргэдэг. Нүүлгэн шилжүүлэлт хийхдээ Монгол улс хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ хэлбэрэлтгүй биелүүлэх ёстой. Албадан нүүлгэлтээс хангалттай хамгаалсан зохицуулалтгүй байж дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор газар өмчлөгч, эзэмшигч болон өмчлөгч, эзэмшигч бус хүмүүсийг газар, орон байрнаас нь нүүлгэх магадлалтай байгаа нь хүний эрхийн талаарх олон улсын хэм хэмжээнд нийцэхгүй юм. Хамгаалалт гэдэг нь бүх талыг бодитоор зөвлөлдөхөд оролцуулах, албадан нүүлгэлт хийлгэхгүйн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаар нүүлгэн шилжүүлэлтээс үүдэн хэн ч орон гэргүй болох ёсгүйг баталгаажуулахыг хэлнэ. Эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, холбогдох журамд газар өмчлөгч, эзэмшигчид гурван талт гэрээнд гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд төсөл хэрэгжүүлэгчид газрыг нь хэрхэн авах талаарх зохицуулалт тодорхой бус байгаа нь сэтгэл түгшээж байна.

Гэр хорооллын дэд бүтцийн газар(ГХДБГ)-ын албан хаагчид дахин төлөвлөлтийн хүрээнд нүүлгэн шилжүүлэлт хийгдсэн тохиолдол одоогоор гараагүй хэмээн Эмнести Интернэшнлд мэдээлсэн. Нүүлгэн шилжүүлэлт хийх талаарх шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар өөрийн гүйцэтгэсэн нүүлгэн шилжүүлэлтийн талаар тоо, бүртгэл хөтөлдөггүй хэмээн Эмнести Интернэшнлд мэдэгдсэн нь ГХДБГ-ын өгсөн мэдээллийг тодруулах боломжийг хүндрэлтэй болгож байна.<sup>51</sup>

Газрын тухай хуульд иргэний газрыг чөлөөлөх ажлыг зөвхөн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийхээр хуульчилжээ.<sup>52</sup> Гэвч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд барилга, орон байрнаас нүүлгэн гаргах тухай шийдвэрийг нүүн гарч байгаа этгээдийн амьдралын нөхцлийг харгалзан ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор өвлийн улиралд тодорхой хугацаагаар түдгэлзүүлэхээс бусад тохиолдолд жилийн аль ч улиралд нүүлгэх ажиллагааг гүйцэтгэж болохоор зохицуулсан нь Газрын тухай хуульд заасан нүүлгэх ажиллагаанд тавьсан хугацааны хязгаарлалтыг сулруулсан байна.<sup>53</sup> Хэдийгээр Засгийн газар нүүлгэх ажиллагааг гүйцэтгээгүй хэмээн мэдэгдсэн ч Улаанбаатар хотод агаарын хэм дунджаар 0°C хэмээс доош хүйтэн байсан 2016 оны 3 дугаар сарын эхээр дахин төлөвлөлтийн төсөлд хамрагдсан газар нүүлгэх ажиллагаа хийгдэж байсныг Эмнести Интернэшнлийн хоёр ажилтан харж байлаа.

<sup>51</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан хаагчидтай Эмнести Интернэшнлийн хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдөр.

<sup>52</sup> Газрын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.4 дэх хэсэг .

<sup>53</sup> Монгол Улсын Их Хурал 2001 оны 1 дүгээр сарын 10-нд баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.6 дахь хэсэг. Уг хуульд 2002 оны 4 дүгээр сарын 12, 6 дугаар сарын 13, 7 дугаар сарын 4-нд; 2003 оны 1 дүгээр сарын 2, 5 дугаар сарын 30-нд; 2005 оны 7 дугаар сарын 7-нд; 2007 оны 8 дугаар сарын 2, 3-нд; 2009 оны 12 дугаар сарын 3-нд; 2010 оны 6 дугаар сарын 10, 12 дугаар сарын 2-нд; 2012 оны 8 дугаар сарын 17-нд; 2013 оны 7 дугаар сарын 5; 2014 оны 1 дүгээр сарын 6, 12 дугаар сарын 5-нд; 2015 оны 2 дугаар сарын 15, 12 дугаар сарын 3-нд, 2016 оны 2 дугаар сарын 4-нд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

### 3.1 ГАЗАР ӨМЧИЛЖ, ЭЗЭМШЭЭГҮЙ ХҮМҮҮСИЙН ХУВЬД ЯМАР НЭГЭН ЭРХ ЭДЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙДАЛ

Албадан нүүлгэлтээс сэргийлэх үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг бол уг ажиллагаанд өртөж буй бүх хүнтэй бодитоор зөвлөлдөж, тэдний санал бодлыг сонсох явдал юм. Гэвч Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, бодлогын дагуу зөвхөн газар өмчлөгч, эзэмшигч ялангуяа, газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээнд албан ёсоор нэр нь бичигдсэн хүн л зөвлөлдөх, нөхөн олговор авах гэх мэт хуулиар олгосон эрхийг эдлэх боломжтой.<sup>54</sup>

Хашааны газрын өмчлөл, эзэмшил нэгээс олон хүний нэр дээр байж болох боловч газрын эрх зөвхөн тухайн өрхийн тэргүүн, эсвэл бичиг баримтаа бүрдүүлж газар эрхийн асуудлыг хөөцөлдсөн хүний нэр дээр олгогдох нь түгээмэл байна.<sup>55</sup>

Гэр бүлийн гишүүн, хамаатан садан хэдий ч, өөрсдийн амьдран суугаа газар болон эд хөрөнгийг өмчлөх, эзэмших албан ёсны эрхгүй хүмүүс өөрсдийн ашиг сонирхлыг газар эзэмшигч, өмчлөгчид даатгадаг. Хэрэв газар өмчлөгч, эзэмшигч этгээд дээр дурдсан хүмүүст нөхөн олговор олгуулах талаар тохиролцоо хийж чадаагүй, эсвэл хийхийг хүсээгүй бол, тэдгээр нь өөр арга хайх ёстой болдог байна. ГХДБГ-ын албан хаагчдын хэлснээр, хэрэв нэг хашаанд олон айл амьдарч байгаа бол нөхөн олговор авах тохиролцоог хир сайн хийх нь зөвхөн газар эзэмшигч, өмчлөгчийн л чадварын асуудал юм байна.<sup>56</sup> Газар болон орон сууцыг түрээслэж амьдардаг хүмүүсийн хувьд дахин төлөвлөлтийн үйл явцад оролцох эрх байхгүй байна.

Одоогоор дахин төлөвлөлтөнд өртөж буй эмэгтэйчүүд, өндөр настан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлогт тохируулан хүн бүрийн тэгш оролцоог хангасан зөвлөлдөх тусгай арга барил байхгүй байна.<sup>57</sup> Тухайлбал, Хот байгуулалтын тухай хуульд дэд бүтцийг шинээр барихдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцлийг хангах талаар хуульчилсан. Гэвч газрын хувьд эрх эзэмшигч байх эсэхээс үл хамааран дэд бүтцийг төлөвлөх, загвар боловсруулахдаа дахин төлөвлөлтийн үйл явцад өртсөөр байгаа хөгжлийн

---

<sup>54</sup> Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3, 3.1.4-д газар эзэмшигч, өмчлөгч, хэрэглэгчийн тухай тодорхойлолтыг өгсөн байна. Газар өмчлөх гэдэг нь "газар өмчлөх" гэж тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг; "газар эзэмших" гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг; "газар ашиглах" гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг гэж тус тус тодорхойлсон байна

<sup>55</sup> Хил хязгааргүй алхам ТББ-тай Эмнести Интернэшнлийн хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдөр.

<sup>56</sup> ГХДБГ-ын албан хаагчидтай Эмнести Интернэшнлийн хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

<sup>57</sup> Монгол Улсын Их Хурал 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Захиргааны ерөнхий хуулийг баталсан бөгөөд энэ хууль 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлээд байна. Энэ хуульд захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй шийдвэр гаргах үйл ажиллагаа, төлөвлөлт зэрэгт иргэдийн оролцоог хангах, сонсох ажиллагааг зохион байгуулж тэдний саналыг авах, мэдэгдэх зэрэг иргэдийн оролцооны эрхийг хангасан олон зүйл сайн шинэлэг зохицуулалт орсон боловч тус хууль хэрэгжиж эхлээд төдий л удаагүй байна.

бэрхшээлтэй иргэдийг оролцуулах, зөвлөлдөх, саналыг нь авах агуулга бүхий зүйл, заалт алга байна. Хэрэв газар өмчлөгч, эзэмшигч этгээд түүний хашаа, эсвэл гэрт нь амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, энэ талаар тохиролцоонд хүрч чадахгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дахин төлөвлөлтийн үйл явцад оролцох өөр арга зам байхгүй байна.<sup>58</sup>

Дахин төлөвлөлт нь нийгмийн янз бүрийн бүлэгт харилцан адилгүй нөлөөлөх хэдий ч Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд тэдний эрхийг эрх тэгш байдлаар хамгаалсан зохицуулалт байхгүй байна. Эмзэг бүлгийнхэн гэх мэт өртөж болох бүх хүний эрхийг хуулиар хамгаалах ёстой. Шаардлагатай тохиолдолд тусгай арга, журмаар уг асуудлыг шийдвэрлэж болох юм.

### 3.2 ОРОН ГЭРГҮЙ БОЛОХ ЭРСДЭЛ

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, холбогдох журамд хувь хүмүүс, ялангуяа түрээслэгч болон газар өмчлөгч, эзэмшигч бус хүмүүсийг албадан нүүлгэлтээс хамгаалах, дахин төлөвлөлтийн улмаас орон гэргүй болох эрсдэлээс урьдчилсан сэргийлсэн зохицуулалт байхгүй байна. Энэ нь гэр хорооллын дахин төлөвлөлт болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг дахин төлөвлөх төсөл, хөтөлбөрт нэгэн адил хамааралтай юм.

Хэрэв төсөл хэрэгжүүлэгчид хоёр болон гурван талт гэрээгээр иргэдийг түр оршин суух эсвэл шинэ байраар хангах үүргээ биелүүлж чадахгүйд хүрвэл газар өмчлөгч, эзэмшигчид ч гэсэн орон гэргүй болох эрсдэлтэй байна. Энэхүү эрсдэл нь газар эсвэл орон сууцаа хувийн барилгын компанид чөлөөлөн өгч, шинэ байр ашиглалтад орох хүртэл хугацаагаар түр оршин суух байранд амьдарч түрээсийн мөнгө авч буй газар өмчлөгч, эзэмшигч иргэдэд хамаатай юм. Эдийн засгийн хүндрэл, бусад шалтгааны улмаас зарим төсөл хэрэгжүүлэгчид барилгын ажлаа эхлүүлэх, үргэлжлүүлэх боломжгүй байдалд хүрсэн. Эмнести Интернэшнлийн уулзсан айлууд санхүүгийн шалтгаанаас үүдэн барилгын ажил саатсанаас тэд орон гэргүй болох вий мөн компаниуд түр байр хөлслөх мөнгийг нь үргэлжлүүлэн олгохгүй байх вий гэсэн айдастай байдгаа хэлж байлаа.

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРООНЫ ЗАРИМ ОРШИН СУУГЧДЫГ ОРОН ГЭРГҮЙ БОЛГОЖЭЭ

**Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт орших ашиглалтын шаардлага хангахгүй, хуучирсан 3 дугаар байрныхны хувьд дахин төлөвлөлтийн төсөл жинхэнэ буруугаар эргэжээ. Байрны дулааны шугам, цонх, хаалгануудыг нь авч хаяснаар барилга хог хаягдлаар дүүрч, хүн амьдрах ямар**

<sup>58</sup> Сонгино бие даан амьдрах төвтэй Эмнести Интернэшнлийн хийсэн ярилцлага, 2015 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төвтэй хийсэн ярилцлага, 2015 оны 11 дугаар сарын 4-ний өдөр. Хэдийгээр энэ тайланд тэгш оролцооны талаар бүрэн судалж гаргаагүй ч, тэгш оролцоог хангахын тулд тусгай арга хэмжээ шаардагдаж болно. Жишээ нь, Дэлхийн банкны тайланд эмэгтэй өрхийн тэргүүнтэй айл эрэгтэй тэргүүнтэй айлтай харьцуулахад санхүүгийн хүндрэлд орох эрсдэл харьцангуй өндөр байна. Дэлхийн банк, Монгол Улс Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгаа ба бодлогын зөвлөмжүүд, 2013 он, энэ хаягаар үзнэ үү: [documents.worldbank.org/curated/en/2013/01/17694501/mongolia-gender-disparities-labor-markets-policy-suggestions](http://documents.worldbank.org/curated/en/2013/01/17694501/mongolia-gender-disparities-labor-markets-policy-suggestions)

**ч бололцоогүй болсон байна. Хөгжлийн бэрхшээлтэй нэг эрэгтэй, бага насны хүүхдүүдтэй нэг айл гээд нийт таван өрх 2015 оны өвлийн хүйтнийг төвийн халаалтгүй байранд өнгөрөөжээ. Улаанбаатар хотод өвөл -30°C хэм хүртэл хүйтэрдэг.**

2015 оны эхээр 2 давхар, боловсон бие засах газар, цэвэр усны шугамгүй 3 дугаар байрны 51 айлын оршин суугчид дээр хувийн барилгын компанийхан ирж одоо байгаа байшинг буулгаж, оронд нь шинэ орон сууц барих санал тавьжээ. Энэ нь боломжийн санал байсан бөгөөд 2015 оны 4-7 дугаар сарын хооронд байрны оршин суугчдаас дор хаяж 28 өрх нөхөх олговор авах гэрээг хувийн компанитай байгуулан байраа чөлөөлж нүүсэн байна. Шинэ орон сууц баригдах нэг жилийн хугацаанд өөр байр түрээслэж амьдрах нөхцөлөөр оршин суугчдад түрээсийн мөнгө олгосон байна. Зарим айлууд компанид итгээгүй учир шинэ орон сууцтай болох хэлэлцээр хийгээгүй байна. Учир нь, аль нэг компаниас ирээд шинэ орон сууцны байр амлах нь тэдний хувьд анхны удаа биш бөгөөд өмнөх компаниуд бүгд амлалтандаа хүрээгүй байсан юм. Гэрээ хийхийг хүсээгүй айлууд, байр түрээслэгч нар амьдарсан хэвээрээ байхад байрны халаалт, дулааны шугамыг авч хаясан байна. Байрны зарим оршин суугчид халаалтыг тухайн компаний төлөөлөгчид авч хаясан гэж Эмнести Интернэшнлд мэдээлсэн боловч, үүнийг батлах боломжгүй байлаа.

Нийслэлийн засаг захиргаанаас оршин суугчидтай гэрээ хийж барилгын ажлыг явуулах гэж байгаа компани нь зөвшөөрөл авсан компани биш гэдгийг мэдэгдэн оршин суугчдад 2015 оны 4 дүгээр сарын 22-нд мэдэгдэл явуулсан байна. Гэвч 2016 оны 3 -5 дугаар саруудад Эмнести Интернэшнл оршин суугчидтай ярилцах үед тэдний зарим нь энэ мэдэгдлийн тухай мэдэхгүй, эсвэл гэрээ хийх үедээ тухайн компани зөвшөөрөлгүй гэдгийг мэдээгүй байсан гэсэн хариулыг өгч байлаа.

Жилийн дараа барилгын ажил зогсонги байдалд орж, түрээсийн мөнгө нь дуусчээ. Түрээсийн мөнгөгүй болсон иргэд хамаатан садныхаа гэрч очиж амьдрах уу, өөрийн мөнгөөр түрээсээ төлөх үү, эсвэл хуучин 3 дугаар байрандаа нүүж очих уу гэсэн сонголтыг хийхээс өөр аргагүй болжээ. Зарим айлуудын хувьд байр нь халаалтгүй, цонх, хаалгагүй учраас амьдрах боломжгүй тул 3 дугаар байр руу нүүж очих ямар ч боломжгүй болсон байна.

Компанитай гэрээ байгуулаагүй хүмүүсийн дунд хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэрт суудаг хүн байна. Тэрээр өвлийг байрандаа өнгөрүүлсэн бөгөөд хамаатнууддаа дараа болж байснаас өөрийн гэртээ байсан нь дээр гэж үздэгээ Эмнести Интернэшнлд ярьсан юм. Өөр очих газаргүй дөрвөн айл 2015 оны өвөл байрандаа өвөлжсөн байна. Компанитай гэрээ байгуулаагүй есөн айл амьдрах нөхцөл байхгүйгээс өөрийн зардлаар 2015 оны өвөл гэрээсээ нүүсэн байна. 2016 оны хавар гадаа дулаарч эхлэхэд өөр газар түрээс төлж амьдрахад хэтэрхий үнэтэй байсан учраас таван айл гэртээ буцаж иржээ.

Байрандаа өвөлжсөн оршин суугчид дулаан байхын тулд зуух галлаж, цахилгаан халаагуур хэрэглэдэг байжээ. Гэвч цахилгааны зардал нь маш өндөр гарч, төлбөр төлөх эх үүсвэргүйн улмаас оршин суугчид цахилгаанаа тасдуулах эрсдэлд оржээ.

Оршин суугчид нийслэл, дүүргийн захиргааны байгууллагуудад удаа дараа хандаж, төвийн халаалтыг холбуулах, байшинг засварлуулах талаар хүсэлт гаргаж байжээ. Түүнчлэн, оршин суугчид Захиргааны хэргийн шүүхэд хандаж хувийн компаний

барилга барих зөвшөөрлийг хүчингүй болгох хүсэлт гаргажээ.<sup>59</sup> Энэхүү тайланг бичих үед компани нь Улсын Дээд Шүүхэд хяналтын шатны журмаар гомдол гаргасан байлаа. Нийслэлийн засаг захиргааны байгууллагууд эхлээд хариуцлагаа хүлээхээс татгалзаж, оршин суугчид гурван талт гэрээ (орон сууц эзэмшигч, компани болон нийслэлийн Засаг даргын хооронд нүүлгэн шилжүүлэлтийн нөхцөл, нөхөн олговрыг зөвшилцөж тохирсон гэрээ) байгуулаагүй учраас үйл явцад оролцох, маргааныг шийдвэрлэх баталгаа гаргахгүй гэжээ.

Эмнести Интернэшнл энэ асуудлын талаар 2016 оны 3 дугаар сард яаралтай уриалга (Яаралтай арга хэмжээ: 77/16, Индекс: АСА 30/3743/2016) гаргаж, нийслэлийн Засаг даргад 3 дугаар байрны бүх оршин суугчийг шаардлагад нийцсэн орон байраар яаралтай хангахыг уриалсан. Нийслэлийн ИТХ-ын даргатай Эмнести Интернэшнл 2016 оны 6 дугаар сарын 13-нд уулзаж, дээрх асуудлыг дахин дэвшүүлсэн бөгөөд 9 дүгээр сард уг асуудлаар дахин хандаад байна.<sup>60</sup>

2016 оны 6 дугаар сарын 24-нд нийслэлийн Засаг дарга тухайн үед 3 дугаар байранд амьдарч байсан 10 өрхийг түр орон байраар хангах, төсөл хэрэгжүүлэгчтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, сонгон шалгаруулалтыг дахин хийх, байрыг битүүмжлэх А/532 дугаар тушаалыг баталжээ.<sup>61</sup> Гэвч 6 дугаар сарын 29-ний сонгуулийн үр дүнгээр Засаг дарга болон эрх баригч нам ялагдснаар асуудал дахин гацаанд орлоо. Энэ тайланг бичих үед 3 дугаар байрны нэг ч оршин суугчийг шаардлагад нийцсэн өөр орон байраар яаралтай хангаагүй байна.

Хэдийгээр Эмнести Интернэшнл 3 дугаар байранд амьдарч байгаа 10 айлыг түр байраар хангах шийдвэрийг дэмжин ажиллаж байгаа боловч, хамаатныхаа гэрт эсвэл өөрийн зардлаар байр түрээслэж байгаа бусад оршин суугчид ч бас шаардлагад нийцсэн өөр орон байраар яаралтай хангагдах ёстой гэж үзэж байна.

Иргэдийн шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг газар өмчлөгч, эзэмшигч, эсвэл хувийн компани гэх мэт "гуравдагч этгээд" зөрчих эрсдэлээс засаг захиргааны байгууллага урьдчилан сэргийлэх ёстой. Ийм зөрчил илэрсэн тохиолдолд нийслэлийн Засаг даргын Тамгын газар гэх мэт холбогдох газрууд уг зөрчлийг даамжруулахгүйгээр зогсоох, оршин суугчдад зөрчигдсөн эрхээ хамгаалуулах, шийдвэрлүүлэх зорилгоор хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх ёстой. Орон байраа өөрсдөө олж чадахгүй хүмүүсийг засаг захиргааны зүгээс шаардлагад нийцсэн өөр орон байраар яаралтай хангах ёстой бөгөөд нүүлгэн шилжүүлэлтийн улмаас нэг ч хүн орон гэргүй болох эсвэл эрхийн нь зөрчигдөх эрсдэлд орох ёсгүйг баталгаажуулах ёстой.

---

<sup>59</sup> Энэ бол Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны 3 дугаар байр гэх мэт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх төслийг хэрэгжүүлэх зөвшөөрөл авсан компанийн эсрэг шүүхийн хэрэг юм. Тус компани нь дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх зөвшөөрлийг авахын тулд хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэж оршин суугчид буруутгаж байгаа юм. Энэ нь оршин суугчидтай хоёр талт гэрээ хийсэн болон тухайн газар нутагт дахин төлөвлөх төслийг хэрэгжүүлэх зөвшөөрөлгүй компанийн тухай юм.

<sup>60</sup> Дэлгэрэнгүй мэдээлэл нь 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Эмнести Интернэшнл, *Монгол Улс: 200 орчим хүн орон гэргүй болох эрсдэлтэй тулгараад байна* (Индекс: АСА 30/3743/2016), мөн 2016 оны 9 дүгээр сарын 8-ний өдрийн (Индекс: АСА 30/4793/2016).

<sup>61</sup> Нийслэлийн Засаг даргын 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн А532 тоот захирамж; албан бус орчуулга нь Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

### 3.3 САЙН ДУРЫН ҮНДСЭН ДЭЭР ҮҮ ЭСВЭЛ ЗААВАЛ НҮҮХ ЁСТОЙ ЮУ

Төсөл хэрэгжүүлэгч газар өмчлөгч, эзэмшигчдийн 80 хувийн дэмжлэгийг авсан үед хэн нэгэн газар өмчлөгч, эзэмшигч төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ хийхээс татгалзаж, газар дээрээ амьдарсаар байж болох эсэх асуудал зарим оршин суугч, ТББ, төрийн албан хаагчдын дунд тодорхойгүй хэвээр байна.

Оршин суугчид, ТББ-ууд 80 хувийн (Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журамд 75 хувь гэж заасан байдаг) босго хүрсэн л бол гурван талт гэрээ байгуулаагүй газар өмчлөгч, эзэмшигч нь багаахан нөхөн олговор аваад нүүхээс өөр аргагүй хэмээн ойлгодог тухайгаа Эмнести Интернэшнлд хэлсэн юм. Зарим оршин суугчид төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулахгүй л бол нөхөн олговор авч чадахгүй байх эрсдэлтэй гэж боддог байна. Үүний нотолгоо нь “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.17-д иргэд сайн дурын үндсэн дээр хоёр болон гурван талт гэрээ байгуулна хэмээн заасан хэдий ч, гурван талт гэрээ байгуулаагүй газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчид газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээгээр нөхөх олговор олгож, газрыг чөлөөлнө гэж заасан байгааг оршин суугчид болон ТББ-ынхан дурдаж байв.<sup>62</sup> (Хавсралтын 2 дугаар хэсгээс дэлгэрүүлж харна уу)

Монголын нэлээд хэдэн ТББ-ыг эгнээндээ нэгтгэсэн Хүний эрхийн ТББ-уудын Форумас НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороонд Монгол Улсын илтгэлийг 2015 оны 6 дугаар сард хэлэлцэхээс өмнө тус хороонд илгээсэн тайландаа:

*“Журмын дагуу, дахин төлөвлөлтийн газар нутагт оршин суудаг газар өмчлөгч, эзэмшигчдийн 75 хувьтай нь зөвшилцөлд хүрч чадсан тохиолдолд дахин төлөвлөлтийн төслийг эхлүүлнэ гэж заасан нь үлдсэн 25 хувьтай нь хэлэлцээр хийх шаардлагагүй болгож байна. Үүний улмаас газар эзэмшигч хүлээн зөвшөөрөөгүй байсан ч нөхөх олговрын оронд газраа өгөхөөс өөр аргагүй байдалд орж болзошгүй болоод байна”.*<sup>63</sup>

УИХ-ын гишүүн Ц. Даваасүрэн 2015 оны 7 дугаар сард 80 хувийн квотын талаар хэвлэлд өгсөн ярилцлагадаа:

*“Сүүлийн үед нэгнийхээ газар руу дайрдаг, булааж авдаг болж... Иргэний өмч рүү халдсан үйл ажиллагаа хавтгайрвал хуулийг нэн даруй өөрчлөх ёстой. Хамаг хөрөнгөө зараад байшин барьсан байхад иргэдийн 80 хувийн саналаар газрыг чөлөөлж нүүлгэнэ гэдэг”.*<sup>64</sup>

<sup>62</sup> Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.16 дахь хэсэг

<sup>63</sup> Хүний эрхийн ТББ-уудын форум, “Монгол Улсад Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийн талаар НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 55 дугаар чуулганы илтгэл, тайлан”, хуудас 8, [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCESCR%2fCSS%2fMNG%2f20525&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCESCR%2fCSS%2fMNG%2f20525&Lang=en)

<sup>64</sup> Зууны мэдээ сонин, *Газраас болж дайтах дөхөж байна*, 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр, дугаар 140; Эмнести Интернэшнлийн архив.

Төрийн албан тушаалтнууд “дахин төлөвлөлтийн талбайгаас хүмүүсийг нүүлгэн шилжүүлэхэд илүү хялбар болгох хүчтэй дүрэм журам шаардлагатай” гэж ярьж байгаа нь гэрээ байгуулахаас татгалзснаар газраа чөлөөлүүлэхэд хүрнэ гэдэг ойлголтыг улам лавшруулж байна. Тухайн үед нийслэлийн Засаг дарга 2013 онд хэвлэлд өгсөн ярилцлагадаа (Хотын Захирагч гэж тус сонинд гарав) дахин төлөвлөлтийн төслийг явуулахад шаардлагатай газрыг авах эрхийг нийслэлийн засаг захиргаанд олгох хэрэгтэй гэсэн утгыг илэрхийлжээ:

*“Ойрын хугацаанд бодлогын түвшинд шийдвэрлэж өгөхгүй бол Үндсэн хуулийн 62.2-т заасан эрхээ эдлэж, нийслэлийн удирдлагын зүгээс газрыг албадан чөлөөлөх асуудлыг журамлана. Ингэснээр нийтийн болон өөрийн эрх ашгаа бодсон ч газраа чөлөөлөх нь зөв гэдгийг журам гарган газрын эздэд ойлгуулах юм байна” гэжээ.<sup>65</sup>*

Түүнчлэн, тухайн ярилцлагад нийслэлийн Засаг дарга үргэлжлүүлэн:

*“Олон улсын жишгийг хараад байхад нийт иргэдийн 70 хувь нь дэмжиж байвал, үлдсэн иргэдэд газрынх нь үнийг өгөөд чөлөөлдөг. Өөрөөр хэлбэл тогтсон үнийг өгөөд хүчээр чөлөөлүүлдэг гэсэн үг... Ингэвэл хүний эрх зөрчиж байгаа юм биш. Яагаад гэхээр газраа чөлөөлүүлэхгүй гэж эсэргүүцэж байгаа хүмүүс нөгөө сайхан амьдрахаар зорьж буй хүмүүсийнхээ эрхийг зөрчиж байгаа юм.*

*Хуучин орон сууцаа шинэ орон сууцаар сольж аятай, тухтай амьдрах гэж буй хүмүүсийнхээ эрхийг зөрчиж байгаа гэж үздэг. Нэг хүний эрх нөгөөгийнхөөрөө хязгаарлагддаг шүү дээ. ...Одоо бол зарим нэг айлуудаас болж ажил гацаж байгаа тохиолдол бий. Тохиролцохыг хүлээхээс өөр арга байхгүй”<sup>66</sup>.*

Албаны хүмүүсийн иймэрхүү ярилцлага, мэдэгдэл нь оршин суугчид, ТББ болон бусдад төөрөгдөл, айдас үүсгэж, гурван талт гэрээ байгуулаагүй бол газраа чөлөөлөх үү, үгүй юу, нүүлгэн суурьшуулалт нь бодит байдал дээр сайн дурын үндсэн дээр хийгдэх үү эсвэл албадан хийгдэх үү гэдэгт эргэлзэхэд хүргэж байна.

Хэлэлцэн тохиролцох тухайд Засгийн газар аль болох уг харилцаанд оролцохгүй байх чиг баримтлаж, дахин суурьшилт нь сайн дурын үндсэн дээр байх ёстой, газар өмчлөгч, эзэмшигч болон төсөл хэрэгжүүлэгчид нүүлгэн шилжүүлэлт, нөхөх олговрын хэмжээг өөр хоорондоо харилцан тохиролцох ёстой хэмээн онцлон хэлсээр ирсэн. Гэвч энэ байдал дахин төлөвлөлтийн төсөл болон эдлэх эрхийнхээ талаар мэдлэг багатай газар өмчлөгч, эзэмшигчид тохиролцооноос аль болох их ашиг олохыг тэмүүлж буй төсөл хэрэгжүүлэгчдэд хууртагдах эрсдэлийг үүсгэж байна. ГХДБГ-ын албан хаагчидтай

<sup>65</sup> Т.Батсайхан, Э.Бат-Үүл: Бид газар албадан чөлөөлөхийг журамлах эрхтэй, Эмнести Интернэшнлийн архив. Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэгт: “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” гэжээ.

<sup>66</sup> Өдрийн сонин, Э.Бат-Үүл: Хотын Захирагч дахин төлөвлөлтийн төслийг танилцууллаа, 2016 оны 3 дугаар сарын 24-ний өдөр, хэвлэмэл хувилбар, хуудас 1 ба 5, Эмнести Интернэшнлийн архив.



ярилцах үед зарим хүн бусадтай харьцуулахад илүү их нөхөх олговор авч байгаа нь тухайн хүн хэр сайн тохиролцогч<sup>67</sup> вэ гэдгээс шалтгаалж байгаа гэсэн. Энэ нь газар өмчлөгч, эзэмшигч, хувийн компаниудын хооронд мэдээлэл, нөөц бололцоо, мэдлэгийн зөрүү байгааг харуулж байна.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудлаар тухайн үеийн нийслэлийн ИТХ-ын дарга Д.Баттулга 2016 оны 3 дугаар сард хэвлэлд өгсөн ярилцлагадаа:

*“Дахин төлөвлөлт дээр барьж байгаа нэг зүйл нь энэ ажилд хот оролцохгүй. Өөрөөр хэлбэл, газар өмчлөгч, төсөл хэрэгжүүлэгч гэсэн хоёр л тал бий. Хоорондоо л тохиролцох ёстой. Газраа байраар, мөнгөөр солих уу гэдгээ хоорондоо ярьж байгаа нь зах зээлийн л зарчим. 2012 оноос өмнө харин Үндсэн хуулиар олгогдсон эрхэд нь халдаж байсан. ... заавал газраа чөлөөл гэдэг байлаа. Харин бид болохоор “Энэ айл өөрийнхөө өмчийг хэдээр яаж өмчлөхөө өөрөө мэдэг” гэсэн. Түүнээс биш хүмүүсийн өмчлөл рүү халдсан, дайрсан зүйл байхгүй” гэж мэдэгдсэн байна.*<sup>68</sup>

Эмнести Интернэшнлтэй ярилцсан нэгэн оршин суугч хоёр талт гэрээнд гарын үсэг зурахаас өөр сонголт түүнд болон түүний гэр бүлд байгаагүй. Учир нь төсөл хэрэгжүүлэгч компани гэрээ байгуулахгүй бол хуульд заасны дагуу түүнийг нүүлгэх болно гэж хэлсэн хэмээн мэдээлсэн. Хэрэв тэд эсэргүүцсээр байх юм бол нөхөх олговор авч чадахгүй ч байж магад гэж төсөл хэрэгжүүлэгч хэлжээ.<sup>69</sup> Бусад оршин суугч, ТББ-ын хүмүүстэй хийсэн ярилцлагаас Эмнести Интернэшнл оршин суугчид төсөл хэрэгжүүлэгчтэй хоёр болон гурван талт гэрээ байгуулахаас өөр аргагүй гэсэн ойлголт түгээмэл байгааг олж харлаа.

### **3.4 ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ БОЛОН ОРШИН СУУГЧДЫН ЭРХИЙН ТАЛААРХ ТОДОРХОЙГҮЙ ЗҮЙЛС**

Дахин төлөвлөлттэй холбоотой хууль, журам, бодлогыг шинээр боловсруулан батлан гаргаж, нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь иргэд ямар эрхтэйгээ мэдэж ухамсарлах, дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа бодитоор хэрхэн хэрэгжих ёстой талаар төөрөгдлийг бий болгож байна. Олон нийтээс гомдол, санал хүлээн авах, хариу өгөх чиг үүрэг бүхий УИХ-ын Өргөдлийн байнгын хороо дахин төлөвлөлтийн талаар оршин суугчдаас гаргасан гомдлыг хүлээн авснаар ажлын хэсэг байгуулж, гомдлын мөрөөр шалгасан байна.

Ажлын хэсэг дараах дүгнэлтэд хүрчээ. Үүнд:

*“Иргэдийг хүлээн авч уулзах, ирүүлж байгаа өргөдөл, гомдлыг судлахад иргэдийн ихэнх хүсэлт, гомдол нь гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаарх үйл ажиллагаа болон эрх зүйн баримт бичгүүдийн талаарх мэдээлэл хомс,*

<sup>67</sup> Эмнести Интернэшнлийн ГХДБГ-тай 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хийсэн ярилцлага.

<sup>68</sup> Э. Энхболд, Д.Баттулга: Нийтлэг эрх ашгийн эсрэг явж байгаа бол намтай нь ч гэсэн ярих асуудал бий, Өдрийн сонин, 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдөр, хуудас 2 ба 11, Эмнести Интернэшнлийн архив.

<sup>69</sup> Дахин төлөвлөлтөд өртсөн оршин суугчидтай хийсэн Эмнести Интернэшнлийн ярилцлага, 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдөр.

*иргэд өөрсдийнхөө үндсэн эрх, түүнийгээ хэрхэн хамгаалах талаарх мэдлэг дутмагаас болж байна. Иймээс гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлж байгаа нийслэлийн төрийн байгууллагууд иргэдэд мэдээлэл, мэдлэг олгох ажлыг илүү үр дүнтэй зохион байгуулж, төслийн талаар олон нийтэд сурталчлах, зөв мэдээлэл хүргэх, олон нийтийн оролцоог хангаж ажиллах тал дээр анхаарах нь зүйтэй байна” гэжээ.<sup>70</sup>*

Ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдөр 12 тоот тогтоол гаргажээ. Уг тогтоолд гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой хууль эрх зүйн орчинг сайжруулах, газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээнд анхаарал тавих, уг төслийн хүрээнд иргэдийн эдлэх эрх, үүргийнх нь талаар иргэдийг мэдээллээр хангах зэрэг гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлэх 7 алхмыг тодорхойлсон байна.<sup>71</sup>

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилтийг хагас жил тутам тайлагнадаг ГХДБГ-ын 2014 оны үйл ажиллагааны тайланд төслийн хэрэгжилттэй холбоотой нийтдээ 204 санал, хүсэлт, гомдол хүлээж авсан гэж дурьдсан байна.<sup>72</sup> Эдгээрээс 75 нь гомдол байсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч зөвхөн газрыг үнэлээд бусад эд хөрөнгийг үнэлэхгүй байна; төсөл хэрэгжүүлэгчийн үнэлгээ хэт доогуур байна; нөхөх олговор гэж санал болгосон орон сууцны талбайн хэмжээ эсвэл өгөх гэсэн байр болон өрөөний тоо нь хангалтгүй байна; төсөл хэрэгжүүлэгчид газар өмчлөгч, эзэмшигч нарыг хууран мэхлэх, айлган сүрдүүлэх арга хэрэглэж байна гэх зэрэг ихэнхдээ төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол байсан байна.<sup>73</sup> 2016 оны эхний 3 сарын байдлаар ГХДБГ иргэдийн гаргасан 47 гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан байна.<sup>74</sup>

Дахин төлөвлөлтөд өртсөн оршин суугчидтай хийсэн ярилцлагаас иргэд дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа, эдлэх эрхийнхээ талаар ойлголт, мэдээлэл хангалтгүй байгааг Эмнести Интернэшнл олж мэдэв. Эрх зүйн болон бодлогын баримт, бичгүүдэд холбогдох мэдээллийг шаардан авах, танилцах, гомдол, санал, хүсэлт өгөх зэрэг иргэдийн эрхийг жагсаан гаргасан боловч Эмнести Интернэшнлийн уулзсан иргэн бүр энэ талаар сайн мэдэхгүй байв. Эмнести Интернэшнлийн уулзсан 2 компани нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, сарын ажлын тайлан гэх мэт мэдээллээ ГХДБГ-т гаргаж өгдөг ч мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байдаггүй тухайгаа хэлсэн. Мөн төсөл хэрэгжүүлэгчээр сонгогдохын тулд төлөвлөсөн барилгын ажлынхаа зарим зураг төслийг оршин суугчдад танилцуулж, саналыг нь авдаг хэмээн ярьсан юм.

---

<sup>70</sup> Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо, “УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу гэр хорооллын нөхцлийг сайжруулах, дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилтийн явц байдалд хяналт, шалгалт хийсэн ажлын хэсгийн танилцуулга”, 2015 он, албан бус орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>71</sup> Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 12 тоот тогтоол; албан бус орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>72</sup> ГХДБГ, *Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газрын үйл ажиллагааны тайлан, 2014 он*, хуудас 75; албан бус орчуулга нь Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>73</sup> ГХДБГ, *Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газрын үйл ажиллагааны тайлан, 2014 он*, хуудас 75; албан бус орчуулга нь Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>74</sup> ГХДБГ-тай хийсэн Эмнести Интернэшнлийн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр.

Төсөл хэрэгжүүлэгчээр сонгогдон барилгын ажлаа эхэлсний дараа хэрэв зөвхөн тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид шаардсан үед мэдээлэл өгөх зорилгоор нийтийн уулзалт хийдэг бөгөөд дахин төлөвлөлтөд хамрагдаж байгаа иргэдэд мэдээлэл хүргэх, солилцох тогтолцоо байхгүй хэмээн нэгэн компани Эмнести Интернэшнлд мэдээлсэн.<sup>75</sup>

Хэдийгээр дүрэм журам батлагдан гарсан ч бодит байдалд хэрэгжилт нь хангалтгүй байна. Газар өмчлөгч, эзэмшигчдахин төлөвлөлтийн төлөвлөгөө, бусад холбогдох баримт бичигтай танилцах эрхтэй байхаар заасан заасан хэдий ч Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хорооны иргэдийн төлөөллийн байгууллагын төлөөлөгчид Эмнести Интернэшнлтэй уулзахдаа тэд компаний төлөвлөгөөтэй танилцахаар хүссэн ч өгөөгүй харинбаримт бичиг эцэслэгдэж батлагдсны дараа л үзэх боломжтой гэсэн хариу авсан тухайгаа ярьсан юм.<sup>76</sup> Нийслэлийн Засаг дарга ажлаа дараагийн удирдлагад хүлээлгэн өгөхийн өмнө Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хороонд төсөл хэрэгжүүлэгч хоёр компаний төсөл хэрэгжүүлэх эрхийг гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн барилгажилтын ажлыг 6 сар хүртэлх хугацаанд эхлүүлээгүй, үйл ажиллагааны зөрчил удаа дараа гаргасан гэх үндэслэлээр 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр захирамж гарган цуцалсан болно.<sup>77</sup>

### 3.5 ЗӨРЧИГДСӨН ЭРХЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн эсвэл ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх төслийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун бус байгаа оршин суугчид нийслэлийн засаг захиргаа, УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд гомдол гаргах, Захиргааны эсвэл Иргэний хэргийн шүүхээр гомдлоо шийдвэрлүүлэх эрхтэй.

Гэр хорооллын дахин төлөвлөлт болон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх төслүүдийн гурван талт гэрээний үлгэрчилсэн загварт маргааныг талууд харилцан зөвшилцөх зарчмаар шийдвэрлэнэ гэж заажээ.<sup>78</sup> Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх төслийн гэрээний үлгэрчилсэн загварт хэрэв маргааныг харилцан тохирох аргаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэхээр заасан байна.<sup>79</sup> ГХДБГ, НЕТГ нь гурван талт гэрээнд (нийслэлийн Засаг даргыг төлөөлж) гарын үсэг зурдаг болохын хувьд газар өмчлөгч, эзэмшигч болон төсөл хэрэгжүүлэгчийн дунд

<sup>75</sup> Барилгын компаниудтай хийсэн Эмнести Интернэшнлийн ярилцлага, 2016 оны 8 дугаар сарын 4 болон 10-ны өдөр.

<sup>76</sup> Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хорооны иргэдийг төлөөлсөн Гэр хорооллын барилгажилтыг дэмжих Саруул хотхон холбоо ТББ-тай хийсэн Эмнести Интернэшнлийн ярилцлага, 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдөр.

<sup>77</sup> Нийслэлийн Засаг даргын 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/568, А/572 тоот захирамж; албан бус орчуулга нь Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>78</sup> Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загварын 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загварын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг; албан бус орчуулга нь Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>79</sup> Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загварын 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг; албан бус орчуулга нь Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

үүссэн маргааныг шийдвэрлэхэд зуучлах үүрэгтэй юм. Гэвч, Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугчид Эмнести Интернэшнлд ГХДБГ асуудлыг шийдвэрлэхэд төдийлөн сайн тусалдаггүй, маргалдагч талуудад байр сууриа ойлголцох хүртэл үргэлжлүүлэн тохиролцох хэрэгтэй гэсэн ердийн хариултаа өгдөг гэж хэлжээ.<sup>80</sup>

Засаг захиргааны байгууллагад гаргасан гомдлыг зарим тохиолдолд зохих ёсоор нь шийдвэрлэж чаддаггүй байна. Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны 3 дугаар байрны дулааны шугамыг салгаж авснаас үүдэн хүн амьдрах аргагүй болоход хэд хэдэн оршин суугч нийслэлийн засаг захиргаанд удаа дараа гомдол гаргасан ч ямар ч арга хэмжээ аваагүй байна. Харин Иргэдийн санал хүлээн авах төвөөс 2015 оны 10 дугаар сард 3 дугаар байрны нөхцөл байдлын талаар хариу өгчээ. Хариу ирүүлсэн албан бичигт дулааны шугамыг дахин холбох боломжгүй бөгөөд компанитай хариуцлага тооцож, хохирлоо төлүүлэх хэрэгтэй гэж оршин суугчдад зөвлөсөн байна.<sup>81</sup> Эмнести Интернэшнл 2016 оны 3 дугаар сард НЕТГ-тай уулзахад хэдийгээр 3 дугаар байранд хүн оршин суух нөхцөл, шаардлагыг хангахгүй байгаа боловч Засгийн газар оршин суугчдыг өөр орон байраар хангах үүрэггүй хэмээн мэдэгдсэн юм.<sup>82</sup>

Зөригдсөн эрхээ хамгаалуулахын тулд оршин суугчид дангаараа, эсвэл хэсэг бүлгээрээ Захиргааны, эсвэл Иргэний хэргийн шүүхэд хандаж болно.<sup>83</sup> Захиргааны хэргийн шүүхэд хандсан үед шүүх гомдлын дагуу мөрдөн шалгах ажиллагааг явуулах үүрэгтэй. Иргэд дангаараа эсвэл бүлгээрээ төсөл хэрэгжүүлэгчтэй байгуулсан гэрээтэй холбоотой асуудлаар Иргэний хэргийн шүүхэд хандан компаний эсрэг маргаан өдүүлэх боломжтой. Захиргааны хэргийн шүүхээс ялгаатай нь маргалдагч тал бүр өөрийн нэхэмжлэлийн шаардлагыг нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөх шаардлагатай. Захиргааны болон иргэний хэрэг маргааны аль аль нь Улсын Дээд Шүүхэд хяналтын журмаар хянагдах боломжтой.

---

<sup>80</sup> Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны оршин суугчдын зөвлөлтэй 2016 оны 5 сарын 25-ны өдөр Эмнести Интернэшнлийн утсаар хийсэн ярилцлагаас. ГХДБГ-ын 2014 оны үйл ажиллагааны тайланд газар өмчлөгч, эзэмшигчдийн мэдлэг, мэдээлэл дутмаг, төсөл хэрэгжүүлэгчдийн сонирхол бага мөн өөрийн байгууллагын гурван талт гэрээ байгуулахаар шаардах эрх хязгаартай зэргээс болж гурван талт гэрээ байгуулах явц удааширч байгааг хүлээн зөвшөөрчээ. *Нийслэлийн Гэр хорооллын хөгжлийн газрын үйл ажиллагааны тайлан*, 2014 он, хуудас 63; албан бус орчуулга нь Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>81</sup> Иргэдийн гомдол, санал хүлээн авах төвөөс 3 дугаар байрны оршин суугчдад өгсөн хариу, гомдлыг 2015 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авч, 10 дугаар сарын 2-ны өдөр хаажээ. Уг хариуны хувийг 3 дугаар байрны оршин суугчид Эмнести Интернэшнлд өгсөн. Албан бус орчуулга нь Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>82</sup> НЕТГ-тай хийсэн Эмнести Интернэшнлийн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдөр.

<sup>83</sup> Захиргааны хэрэг гэдэг нь иргэн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эрхээ сэргээн тогтоолгохоор Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаснаар хуульд заасны дагуу захиргааны хэрэг үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй хэрэг, маргааныг ойлгоно.

Дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжиж буй газарт оршин сууж байгаа иргэд хоёр, гурван талт гэрээний зөрчлүүдийг шийдвэрлүүлэхээр шүүхэд хандах хүсэлгүй байдгаа Эмнести Интернэшнлд ярьсан юм.<sup>84</sup> Тухайн компани аль хэдийн санхүүгийн хүнд байдалд орчихсон байхад оршин суугчид шүүхэд хандах нь нөхөн олговор авч чадахгүй хоцорч, төслийн үйл ажиллагаанд саад болох эрсдэлтэйхэмээн сэтгэл зовниж явдаг тухайгаа Эмнести Интернэшнлд хэлж байв. 3 дугаар байр болон ойролцоох байрны оршин суугчид төсөл хэрэгжүүлэгч компаний дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг цуцлуулах зорилгоор Захиргааны хэргийн шүүхэд 2013 оны 4 дүгээр сард ханджээ. Шүүхэд нэхэмжлэл гаргаснаас хойш 3 жил өнгөрсөн хэдий ч уг компани Улсын Дээд Шүүхэд хяналтын журмаар гомдол гаргаад байна. Хэдийгээр, 3 дугаар байрны оршин суугчид тун яаралтай хугацаанд нөхцөл байдлаа засч, залруулах зорилгооршүүхэд хандсан ч энэ нь цаг хугацаа, үр дүнгийн хувьд өр өгөөжөө өгөөгүй юм. Нөгөө талаас, НЕТГ 3 дугаар байрны оршин суугчдын асуудлаар шүүхийн эцсийн шийдвэрийг хүлээж байна гэж Эмнести Интернэшнлд ярьсан нь тухайн иргэдийн зовлонг уртасгах, асуудлыг нь тодорхой бус, анхаарлын гадна байлгаж байна.

---

<sup>84</sup> Компанитай асуудлыг хурцатгахыг хүсэхгүй байгаа учраас нэрээ нууцлахыг хүссэн оршин суугчдын түр зөвлөлтэй 2015 оны 11 дүгээр сараас 2016 оны 6 дугаар сарын хооронд хийсэн Эмнести Интернэшнлийн ярилцлагаас, Улаанбаатар хот.

## 4. ДҮГНЭЛТ, ҮНДСЭН ЗӨВЛӨМЖ

### 4.1 ГОЛ ҮР ДҮН

Монгол Улсад дахин төлөвлөлт аль хэдийн хэрэгжиж байгаа ч холбогдох эрх зүй, бодлогууд нь хоцорч гарч байна. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, дахин суурьшихтай холбоотой мэдээлэл дутмагаас шалтгаалан дахин төлөвлөлтийн хөтөлбөр зөв хэрэгжихгүй байгаагийн зэрэгцээ бодитоор зөвлөлдөх тухай олон улсын хэм хэмжээнд нийцэхгүй байна. Нийслэлийн засаг захиргаа дахин төлөвлөлтөд өртөж буй иргэдийг шууд хувийн компаниудтай тохиролцон нөхөх олговроо олж ав хэмээн зөнд нь орхиж байна. Үүний улмаас ямар байдлаар нөхөн олговроо тохиролцох нь тодорхойгүй, дээр дурдсан дахин төлөвлөлтөд өртөж байгаа иргэд эдлэх эрхээ мэдэхгүй, төөрөлдөж байна.

Одоогийн зохион байгуулалт нь үйл явцыг хангалттай зохицуулж, хянаж чадахгүй, мөн иргэдийн шаардлага нийцсэн орон байртай байх эрхийг үр дүнтэй хамгаалахгүй байна. Энэхүү тайланг бичих үед гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, батлуулахаар хүлээж байсан. Тус журам нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудтай илүү нийцэж байгаа ч тухайн хуулиудын алдааг давтсанаас гадна дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа бодит амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхойгүй зүйл олон тусгажээ. Шинэ журам нь албадан нүүлгэлт, орон гэргүй болох эрсдэлээс хамгаалахын зэрэгцээ дахин төлөвлөлтөд өртөж буй иргэдийн эрхийг, тухайлбал бодитоор зөвлөлдөх, мэдээллээр хангагдах, шүүхээр эрхээ хамгаалуулах тухай мэдээллийг илүү тодорхой тусгаж байж үр дүнтэй журам болно.

Засгийн газраас тодорхой, уялдаатай, шаардлага хангахуйц хууль, журам гаргаагүй, хууль сахиулах, хянах тогтолцоо бүрдээгүй байгаа нь дахин төлөвлөлтөд хамрагдсан газар нутгийн иргэд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ зөрчүүлэх эрсдэлтэй байгаа бөгөөд Эмнести Интернэшнл дараах зөрчил, дутагдлыг олж тогтоолоо. Үүнд:

- Оршин суугаа газар, орон байраа хууль ёсоор өмчилж, эзэмшдэггүй иргэдийн дахин төлөвлөлтийн асуудлаарх зөвлөлдөх үйл ажиллагаанд оролцох эрхийг хууль болон бодлогын хэмжээнд хүлээн зөвшөөрөөгүй байна;
- Албадан нүүлгэх, орон гэргүй болох эрсдэлээс хамгаалуулах баталгаа байхгүй байна;
- Засгийн газрын агентлагууд, хувийн барилгын компаниуд тодорхой мэдээллээр хангадаггүйгээс болж нүүлгэн шилжүүлэлт сайн дурын үндсэн дээр үү эсвэл заавал уу гэдэг талаар оршин суугчид ихэнхдээ буруу мэдээлэлтэй эсвэл ойлголтгүй байна;
- Эрх зүйн болон бодлогын орчинд оруулж буй өөрчлөлтөөс үүдэн дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа, иргэдийн эрх тодорхойгүй болж, шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх зөрчигдөх эрсдэлд оруулж байна;
- Хөндөгдсөн эрхийг сэргээх талаар хууль, журам, бодлого нь ойлгомжгүй, дахин төлөвлөлтөд өртөн хохирсон иргэдэд гомдол гаргах, маргаан шийдвэрлүүлэх сонголтыг тодорхой зааж өгөөгүй байна

Монгол Улсын Засгийн газар хүн амынхаа шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг үр дүнтэй хамгаалахын тулд газар өмчлөгч, хувийн компани гэх мэт гуравдагч этгээдийн зүгээс энэхүү эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх ёстой. Ийм зөрчил гарсан тохиолдолд, холбогдох засаг захиргааны байгууллага зөрчлийг цааш даамжрахаас сэргийлэх арга хэмжээ авч, эрх нь зөрчигдсөн хүмүүст хуулийн дагуу хохирлоо барагдуулах, эрхээ шүүхээр хамгаалуулах боломжоор хангах хэрэгтэй. Одоогийн эрх зүйн, бодлогын тогтолцооны алдаа дутагдлыг арилгахын тулд Эмнести Интернэшнл эрх баригчдыг дараах зөвлөмжүүдийг авч хэрэгжүүлэхийг уриалж байна.

## 4.2 ЗӨВЛӨМЖ

### Нийслэлийн засаг захиргаанд:

- Хот, суурин газрын дахин төлөвлөлтөд өртөж буй хүмүүс, ялангуяа оршин суугчдын төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ хийхээс татгалзах эрх, үүнээс үүдэн гарах үр дагаврын талаар олон нийтэд тайлбарлаж мэдүүлэх;
- Хүн бүр, тэр тусмаа өмчлөх, эзэмшлийн баримт бичиггүй хүмүүсийг албадан нүүлгэх, орон гэргүй болох эрсдэлээс хамгаалж, үүнийг баталгаажуулах;
- Дахин төлөвлөлтөд өртөж буй хүн бүрийг, түүний дотор өмчлөл, эзэмшлийн баримт бичиггүй хүмүүсийг дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны тухай шаардлагатай мэдээллээр хангах, тухайн мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, олж авахад хялбар байх ёстой. Иргэдийн оролцох, зөвлөлдөх, шүүхээр эрхээ хамгаалуулах, эрх зүйн туслалцаа авах зэрэг эрхээ хэрхэн эдлэх талаар мэдээлэлд оруулах ёстой;
- Газар, орон сууц өмчлөгч, эзэмшигч бус хүмүүс, дахин төлөвлөлтөд өртөж буй иргэдийн ашиг, сонирхлыг төлөөлж ажиллаж буй бусад хүмүүсийн эрхийг баталгаажуулж, дахин төлөвлөлтийн үйл явцад оролцох боломж бололцоог шийдэж, нийтэд мэдээлэх;
- Дахин төлөвлөлттэй холбоотой мэдээллийг нийтэд хүртээмжтэй, олоход хялбар болгох, мөн төслийн үйл ажиллагааны талаар санал, хэлэлцүүлгийг аль болох нээлттэй, шударга явуулах бололцоог нээх зорилгоор зөвлөлдөх хугацааг уртасгах, засаг захиргааны ажилтнууд өөрсдөө оршин суугчидтай ярилцаж, санал бодлыг нь сонсох;
- Эмэгтэйчүүд, үндэстний цөөнх гэх мэт нийгэмд эзлэх байр суурь, хүлээн зөвшөөрөгдсөн байдал зэргээсээ болж дахин төлөвлөлтийн үйл явдалд оролцож чадахгүй байж болзошгүй хүмүүст төслийн зүгээс харилцан адилгүй үр дагавар авчрах магадлалтай гэдгийг хүлээн зөвшөөрч, хүн амын тэдгээр бүлгүүдийн оролцоог хангах тусгайлсан арга хэмжээ авах;
- Эдэлгээний хугацаа дуусч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцнаас нүүхээс татгалзаж буй хүмүүсийн асуудлыг шийдэх бүх боломжийг судалсны эцэст нүүлгэхээс өөр аргагүй болбол, хүний эрхийн талаарх олон улсын хэм хэмжээнд заасан шаардлагуудын дагуу нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулж, дахин суурьших орон байр санал болгох;

#### **Барилга, хот байгуулалтын яаманд:**

- Албадан нүүлгэхийг шууд хориглосон хууль санаачилж, хэрэгжүүлэх. Түрээсийн гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран бүх түрээслэгчид нүүлгэн шилжүүлэх тухай мэдэгдлийг хангалттай хугацааны өмнө авах зэрэг арга хэмжээг тусгах замаар орон эргүй болох эрсдэлээс хамгаалж, зохицуулалтаа улам сайжруулах;
- Ажлын хэсгээс боловсруулсан бодлого, журмын нэмэлт өөрчлөлт болгон нэг талаас хүний эрхийн талаарх олон улсын эрх зүй, хэм хэмжээ, нөгөө талаас дотоодын дахин төлөвлөлттэй холбоотой хууль тогтоомжид нийцсэн байх ёстой бөгөөд дахин төлөвлөлтөд өртөж буй оршин суугчдын эрх ашгийг дээдлэн хамгаалах шаардлагатай. Дахин төлөвлөлтийн төслийн үйл явц, үүнд өртөж буй хувь хүн, олон нийтийн эдлэх эрхийн асуудалд ямар нэгэн тодорхойгүй зүйл байх ёсгүй;
- Хяналтыг хараат бус байгууллагаар хийдэг тогтолцоог бий болгох. Энэхүү хараат бус байгууллага нь хүний эрхийн зөрчил гарсан эсэх дээр үнэлгээ өгөх, ийм зөрчлийн талаар олон нийтээс гомдол хүлээн авах бүрэн эрхтэй байх нь зүйтэй. Дахин төлөвлөлтийн үйл явцтай холбоотой гарсан хүний эрхийн зөрчлийн хариуцлагыг төсөл хэрэгжүүлэгч болон Засгийн газартай тооцох эрхийг энэ хараат бус байгууллагад өгөх шаардлагатай.

#### **Монгол Улсын Их Хуралд:**

- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль болон бусад холбоотой хууль журмуудад дахин төлөвлөлтийн үйл явцад өртөж буй хүн бүрийн эрхийг, ялангуяа бодитоор зөвлөлдөж, санал бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулах нэмэлт өөрчлөлтийг оруулах;
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд газар өмчлөгч, эзэмшигч бус хүмүүсийн эрхийг баталгаажуулах нэмэлт өөрчлөлтийг оруулснаар нийгмийн бүх төлөөлөл мэдээлэл авах, зөвлөлдөх, санал бодлоо илэрхийлэх бололцоог олгох;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.8 дахь заалтыг Газрын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх заалттай нийцүүлэх нэмэлт өөрчлөлтийг оруулж, нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зөвхөн 5 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15-ны хооронд явуулдаг болгох;

#### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт:**

- Нэг талаас, НҮБ-ын Хөгжилд суурилсан нүүлгэлт, шилжилт хөдөлгөөний үндсэн зарчим, удирдамжид үндэслэсэн, нөгөө талаас хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн нүүлгэн шилжүүлэх журмыг боловсруулах. Энэхүү журамд нүүлгэн шилжүүлэх ажиллагаа гүйцэтгэхдээ хангалттай мэдээлэл, мэдэгдэл өгөх, гүйцэтгэж буй албан тушаалтнууд таних тэмдэг зүүх ёстой гэх мэт шаардлагуудыг тусгавал зохино. Өвлийн улиралд нүүлгэн шилжүүлэлт явуулахыг зогсоох;
- Хэдэн удаа нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гүйцэтгэсэн, үүний хэд нь дахин төлөвлөлтийн төсөлтэй холбоотой байсан талаарх тоон мэдээллийг бүртгэж, хадгалах.



# ХАВСРАЛТ: ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ТӨЛӨВЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО

Монгол Улсад хот, суурин газрыг дахин хөгжүүлэхтэй холбоотой харилцааг олон тооны дотоодын хууль, нийслэлийн удирдлагаас баталсан бодлогын болон эрх зүйн актуудаар зохицуулж байгаа ч давхцдаг, зарим талаараа зөрчилдсөн ч байна.

## 1. ДОТООДЫН ХУУЛЬ, ТОГТООМЖ

Хот төлөвлөлттэй холбоотой үндэсний хэмжээний гол хууль, тогтоомж нь Хот байгуулалтын тухай хууль (2008), Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015) юм.<sup>85</sup>

### ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ БА ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

Хот байгуулалтын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг 2008 оны 5 дугаар сард баталсан бөгөөд 2015 оны 2, 6, 11 дүгээр сард тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Энэ хуулийн зорилго нь хот, тосгоныг хот төлөвлөлтийн дагуу барьж байгуулах, төлөвлөлтийн төсөл нь санхүүгийн хувьд тогтвортой, холбогдох бодлого төлөвлөгөөний дагуу хэрэгжихэд “төр, аж ахуйн нэгж, иргэний” хооронд үүсэх харилцааг зохицуулах юм (хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг).

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг 2015 оны 6 дугаар сард баталсан бөгөөд хот, суурин газрын барилгажсан хэсгийг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулж, “иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг” хангах зорилготой ( хуулийн 1 дүгээр зүйл). Энэ хуулийн дагуу холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилт зохицуулалтыг хангахаар заасан байна. Тийм учраас Газрын тухай хууль 2003 онд батлагдсанаас хойш нийт 15 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсны 4 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн 2015 онд оруулсан байна. Хот байгуулалтын тухай хуулийг 2008 онд баталснаас хойш 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь бүгд 2015 онд байжээ. Түүнчлэн, энэ тайланг бичих үед Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг батлагдахаас өмнө 2013 оноос

---

<sup>85</sup> Бусад хууль тогтоомж гэдэг нь Газрын тухай хууль, Орон сууцны тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Барилгын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль зэргийг хамрах боловч эдгээр нь хот, суурин газрыг дахин хөгжүүлэхтэй шууд хамааралгүй, мөн энэ тайлангийн хамрах хүрээнээс гадна болно.

нийслэлийн түвшинд батлагдаж, хэрэгжиж байсан журамд Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)-аас өөрчлөлт оруулж байгаа.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуультай нийцүүлэх зорилгоор БХБЯ бусад олон журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж байна. Тухайлбал, 2016 оны 7 дугаар сарын 5-нд Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих журмыг Барилга, хот байгуулалтын сайд баталсан байна. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу энэ журам нь ашиглалтын шаардлага хангахгүй гэж тогтоогдсон нийтийн орон сууцны байрыг дахин төлөвлөх, барих алхмуудыг заажээ. Өмнөх Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцны үйл ажиллагааны журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчийн Хурлаар 2014 оны 6 дугаар сард баталсан бөгөөд шинэ журам нь үүнийг орлох юм. Мөн БХБЯ Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны шинэ журмыг боловсруулсан бөгөөд хэрэв батлагдвал, нийслэлийн түвшинд батлагдаж, одоо мөрдөгдөж байгаа Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам нь хүчингүй болно.

Хот байгуулалтын тухай болон Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн аль аль нь хэрэгжүүлэх үндсэн зарчмуудаа тодорхойлж гаргасан байдаг. Хот байгуулалтын тухай хуулийн зарчимд хүний аюулгүй байдал, экологи, эдийн засаг ба нийгмийн хөгжлийг тэнцвэртэй хөгжүүлж, хөгжлийн үйл явцад оролцож буй тал болгоны тэгш эрхийг хангахыг заажээ.<sup>86</sup> Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн зарчмууд нь нийтийн эрх ашгийг эрхэмлэх, олон нийтийн оролцоог хангах гэж заасан байна.<sup>87</sup> Гэхдээ эдгээр хоёр хуульд “иргэн” гэдэг нэр томъёог ашигласан нь хуулийн хамгаалалт монгол иргэдээс бусад “хүнд” үйлчлэхгүй мэтээр ойлгогдож байна.

Хот байгуулалтын тухай хуулийн дагуу хот төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэхэд нийслэл, орон нутагт маш олон төрлийн баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай бөгөөд үүнд бүсийн хөгжлийн төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө; хот төлөвлөлтийн суурь судалгаа, хот, тосгоны дахин хөгжүүлэх төслийн төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө зэрэг орж байна. (хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.5). Харин Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд “Хот байгуулалтын тухай хуулийн дагуу дахин төлөвлөлтийн төслийн баримт бичгийг бүрдүүлнэ” гэж заажээ (хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 14 дүгээр зүйлийн 14.2).

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу, хот суурин газрыг дахин төлөвлөх үйл явцыг, төлөвлөх, хэрэгжүүлэх, хаалт гэж дөрвөн үе шатад хуваасан байна. Үйл ажиллагааг хэрэгжүүлэх үе шатын талаар 3 дугаар бүлэгт төсөл хэрэгжүүлэгчийг сонгох (хуулийн 19 дүгээр зүйл), дахин төлөвлөлтийн талбайг сонгох (хуулийн 20 дугаар зүйл) шаардлагуудыг заасан байна.

Хот байгуулах болон дахин төлөвлөх үйл ажиллагаанд оролцох байгууллагуудын эрх, үүргийг хоёр хуульд ч тодорхой заасан байна. Тухайлбал, Хот байгуулалтын тухай хууль нь хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүргийг тодорхойлж, хот байгуулалтын тухай хууль тогтоомж, норм, дүрэм, журам, стандартыг дагаж мөрдөн байгаль орчны бохирдлоос сэргийлж, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангана гэж тусгажээ (хуулийн 22 дугаар зүйл).

<sup>86</sup> Хот байгуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг.

<sup>87</sup> Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйл.

Харин Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд газар өмчлөгч, эзэмшигч болон төсөл хэрэгжүүлэгчийн эрх, үүргийг тус тусад нь тодорхойлсон ч газар өмчлөгч, эзэмшигч бус хүмүүст эдлэх эрх, хариуцах үүрэг гэж тусгаж өгөөгүй байна. Мөн Хот байгуулалтын тухай хуульд ч газар өмчлөгч, эзэмшигч бус хүмүүсийн эрх, үүргийг тодорхой заасан зүйл, заалт байхгүй байна. Энэ хоёр хуульд аль нь эрх, аль нь үүрэг болох нь тодорхой бус байна.

## **ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 22 ДУГААР ЗҮЙЛ:**

### **Төсөлд оролцогч иргэдийн эрх, үүрэг:**

- төсөл хэрэгжүүлэх талаар санал өгөх;
- газар, үл хөдлөх эд хөрөнгөө үнэлэх, үнэлүүлэх;
- төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, холбогдох бусад баримт бичигтэй танилцах, танилцуулахыг шаардах;
- төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулах, хэлэлцээр хийх;
- төслийг дэмжээгүй газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчийг төсөлд хамруулах талаар санаачлага гаргах, шаардлага тавих;
- төслийн үйл ажиллагаатай танилцах, мэдээлэл авах, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах;
- төслийн хугацаанд түр суурьших газар, байр, сууцаар хангагдах;
- газар, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой баримт бичгийн зөрчилгүй байх;
- төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээлэл, баримт бичгийг үнэн, зөв, бүрэн гаргаж өгөх;
- төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэдийн төлөөллийн байгууллагаар дамжуулан оролцох;
- хяналтын хороонд төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол гаргах;

## ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 23 ДУГААР ЗҮЙЛ:

### Төсөл хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг:

- газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй хамтран хөндлөнгийн эрх бүхий этгээдээр газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг хийлгэх;
- сонгосон талбай дахь газар, үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, худалдан авах үнийн саналыг өмчлөгч, эзэмшигчид танилцуулах;
- төсөл хэрэгжүүлэхтэй холбогдох үйл ажиллагааны зардал, хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах;
- сонгосон талбай дахь газар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчийн гаргасан хүсэлтийг үндэслэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах;
- төсөл, төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй харилцан тохиролцож гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг хамтран дүгнэх;
- төслийн хэрэгжилтийн талаар оролцогч талуудад тайлагнах, хяналтын хороогоор хэлэлцүүлэх;
- төсөлд оролцогч талуудыг төсөл, төлөвлөгөөтэй холбоотой үнэн, зөв мэдээ, тооцоо судалгаагаар хангаж, шаардсан мэдээллийг гаргаж өгөх;
- төсөл хэрэгжүүлэхэд байгаль орчны, эрүүл ахуйн, аюулгүй байдлын болон бусад холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журам, стандартын шаардлагыг мөрдөх;
- төсөл хэрэгжүүлэхэд Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйл<sup>88</sup>, Хот байгуулалтын тухай хуулийн 24 дүгээр<sup>89</sup> зүйлийг баримтлах

Хот байгуулалтын тухай хуульд хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад нүүлгэн шилжүүлэх шаардлага тохиолдвол яах талаар мэдээлэл байхгүй байгаа нь анхаарал татаж байна. Харин Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд газар өмчлөгч, эзэмшигчтэй харилцан тохиролцоогүй тохиолдолд хуулийн дагуу “нөхөх олговортойгоор газар чөлөөлөх” зорилгоор төсөл хэрэгжүүлэгч шүүхэд хандаж болно гэж заасан байна (хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.3 в).

<sup>88</sup> Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх, үүргийг зааж өгсөн байна.

<sup>89</sup> Хот байгуулалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлд хот байгуулалтын үйл ажиллагаар хориглосон зүйлийг зааж өгчээ.

## ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ХЯНАЛТ

Хот байгуулалтын тухай болон Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухайхуулийн аль алинд хот байгуулах болон дахин төлөвлөлтийн төслүүдийг хянах үйл явцыг тусгажээ.<sup>90</sup> Гэвч хоёр хуулийн дагуу төрийн захиргааны байгууллагуудын үүрэг, оролцоо давхцаж байгаагаас энэхүү хянах үйл явц яаж явагдах талаар ойлгоход төвөгтэй болгож байна. Түүнчлэн хяналтын үйл явцыг хэрэгжүүлэхэд дутагдал байгаа нь оршин суугчдын эрх зөрчигдөх эрсдэлийг үүсгэж байна. Жишээ нь, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд төсөл хэрэгжүүлэгч оршин суугчийн өмчилж буй газар, эсвэл эд хөрөнгийг үнэлүүлэх ёстой бөгөөд газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчтэй хамтарч үнэлгээг гуравдагч этгээдээр хийлгэнэ гэжээ. Гэвч Эмнести Интернэшнлтэй ярилцсан гурван компанигаар болон үл хөдлөх эд хөрөнгийг гуравдагч байгууллагаар бараг үнэлүүлдэггүй, харин компани болон өмчлөгчид тухайн газар эсвэл үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээн дээр тохирч чадаагүй тохиолдолд хааяа нэг гуравдагч байгууллагыг оролцуулдаг болохоо мэдээлсэн юм.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.2 дахь заалтад нөхөх олговрын хэмжээг тогтоох зорилгоор үнэлгээг Хяналтын хороо хийх эрхтэйг заасан байна. Гэвч бодит байдал дээр нөхөх олговрыг зөвшилцөх үед Хяналтын хороог байгуулаагүй байдаг учраас үнэлгээг яаж хийх нь тодорхойгүй байна. Тус хуулийн дагуу Хяналтын хороог зөвхөн гурав дахь үе шат буюу төслийг хэрэгжүүлэх шатанд байгуулдаг бөгөөд энэ үед төсөл хэрэгжүүлэгч болон газар өмчлөгч, эзэмшигч нар аль хэдийн нөхөх олговрын хэмжээг тохирчихсон байдаг байна.

Хяналтын хороо нь төслийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй. Гэвч БХБЯ-тай хийсэн уулзалтын үеэр Хяналтын хороо хэмээх нэг ч хороо одоогоор байгуулагдаагүй байгаа. Гэр хорооллыг дахин төлөвлөх шинэ журам болон бусад холбогдох журмууд батлагдаж, яамны холбогдох газраас хуультай нийцэж буй эсэхэд дүгнэлт өгсний дараа ирээдүйд энэ хороо байгуулагдана гэж Эмнести Интернэшнлд мэдээлсэн.<sup>91</sup> 2016 оны 7 дугаар сард батлагдсан Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журамд “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу Хяналтын хороог байгуулах ёстой” гэжээ.<sup>92</sup> Түүнчлэн, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ гэж заажээ. БХБЯ нь Улаанбаатар хотын дахин төлөвлөлтийн төслийн хувьд энэ үйл ажиллагааг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хийж гүйцэтгэх ёстой гэсэн байр суурьтай байна.<sup>93</sup>

<sup>90</sup> Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 7.1.9, 8 дугаар зүйлийн 8.13, 8.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.14, 10 дугаар зүйлийн 10.1.3, 14 дүгээр зүйлийн 14.7.4, 23 дугаар зүйлийн 23.1.5, 23.1.6 дахь заалт.

<sup>91</sup> Эмнести Интернэшнлийн БХБЯ-тай хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 14-ны өдөр, БХБЯ-наас Эмнести Интернэшнлд 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр ирүүлсэн захидал, д/д 01/2343.

<sup>92</sup> Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын 5.7.

<sup>93</sup> БХБЯ-наас Эмнести Интернэшнлд 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр ирүүлсэн захидал, д/д 01/2343.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд иргэдийн төлөөллийн байгууллагыг байгуулах гэж заасан нь олон нийтийн оролцоог дэмжсэн нэг арга болсон. Энэ байгууллагыг төслийн бэлтгэл үе шатанд байгуулах (хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.1) хэрэгтэй бөгөөд 22 дугаар зүйлд “сайн дурын үндсэн дээр нэгдсэн байх” ёстой гэж заажээ. Хуульд тодорхойлсноор ийм байгууллагыг газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчийн төлөөлөл оролцсон ашгийн төлөө бус байгууллага гэж үздэг (мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3).

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, энэ талаарх нийслэлийн Засаг даргын тайланг хэлэлцэх үүрэгтэй (хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3). Төсөл хэрэгжүүлэгч байгууллага ч гэсэн нийслэлийн Засаг дарга газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй гэрээний биелэлтийг хамтран дүгнэх, төслийн хэрэгжилтийн талаар оролцогч талуудад тайлагнах, Хяналтын Хороогоор хэлэлцүүлэх үүрэг хүлээж байна (хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.5, 23.1.6). Түүнчлэн тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.4в-д төслийн хэрэгжилтийн тайлан, санхүүгийн бүртгэл, тооцоог гаргаж, гэрээний биелэлтийг дүгнэн Хяналтын Хороогоор хэлэлцүүлж үнэлгээ, дүгнэлтийг гаргуулах хэрэгтэй гэж заасан байна. Гэвч Эмнести Интернэшнлтэй уулзсан хоёр компани төслийн хэрэгжилттэй холбоотой тайлангаа ГХДБГ-т явуулдаг ч, нийтэд нээлттэй биш гэж байсан юм.<sup>94</sup>

## 2. ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ

Хуулиас гадна дахин хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлсон журмууд гэж байна. Эдгээр журам нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нийцсэн, илүү дэлгэрэнгүй тодруулсан байх ёстой. ГХДБГ нь гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэхдээ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг 2015 оны 6 сард батлагдахаас өмнө нийслэлийн түвшинд батлагдсан Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмыг мөрдөж байна. Харин НЕТГ ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх төсөлд нийслэлийн түвшинд баталсан үйл ажиллагааны журмыг мөрддөг байсан. БХБЯ-ны ажлын хэсгээс боловсруулсан Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх тухай шинэ журмыг БХБ-ын Сайд 2016 оны 7 дугаар сард баталжээ.<sup>95</sup> Тэгэхээр энэ шинэ журмыг нийслэлийн түвшинд баталсан өмнөх журмын оронд хэрэглэнэ гэсэн үг юм.

---

<sup>94</sup> Эмнести Интернэшнлийн барилгын компаниудтай хийсэн уулзалт, 2016 оны 8 дугаар сарын 4, 10-ны өдөр.

<sup>95</sup> Эмнести Интернэшнлийн БХБЯ-тай хийсэн ярилцлага, 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдөр. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.6-д Барилга, хот байгуулалтын яамнь хот, суурин газрыг дахин хөгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, заавар, норм, нормативыг батлан мөрдүүлэх, стандартыг хэрэгжүүлэх; хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журмыг батлах эрхтэй гэж заасан байна.

### ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам нь гэр хорооллыг барилгажуулах төслийг боловсруулах, хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлсон байдаг (журмын 1 дүгээр зүйлийн 1.3.1). Одоо мөрдөгдөж буй Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлын тогтоолоор 2013 онд баталжээ. БХБЯ-ны ажлын хэсгээс Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуультай уг журмыг нийцүүлэн шинэ журам боловсруулаад байна. Энэхүү тайланг бичих үед шинэ журам хараахан батлагдаагүй байв. БХБ-ын Сайд журмыг баталж, бүртгэлд оруулсны дараа Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны шинэ журам одоо мөрдөгдөж буй журмыг халах юм.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу дахин төлөвлөлтийн төслийн хамгийн эхний алхам бол талбайг сонгох юм. Хэдийгээр Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлд талбайг сонгох шаардлагуудыг заасан боловч, одоогоор 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдөр БХБ-ын Сайдын баталсан “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам”-ыг мөрдөж байна.<sup>96</sup> Дахин төлөвлөлттэй холбоотой хууль эрх зүйн болон бодлогын орчин байнга өөрчлөгдөж байгааг энэ жишээнээс харж болох бөгөөд энэ байдал нь оршин суугчдын дунд төөрөгдөл үүсгэж байгаа юм.

Төсөл хэрэгжүүлэгч хэмээгдэгч хувийн барилгын компанийг сонгон шалгаруулах хоёр үе шат байна. Эхний шатанд газар өмчлөгч, эзэмшигчдээс аль компаниар дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэхийг хүсэж байгаа талаар саналыг нь хураана. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.14-д зааснаар Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл (ГХОСТ) шалгаруулалтад оролцож буй компаниудын саналыг танилцуулах, оршин суугчдын саналыг хураах, Төслийн удирдах хороонд үр дүнг танилцуулах үүрэгтэй.<sup>97</sup> Гэвч тухайн компанийг ялагчаар тодруулахын тулд оршин суугчдын хэдэн хувь саналаа өгсөн байх ёстой, хамгийн багадаа хэдэн хувийн санал авч байж ялагч болох тухай журамд тодорхой дурдаагүй байна. Мөн журамд энэхүү сонгон шалгаруулалт, санал хураалтад хамгийн ихдээ, эсвэл багадаа хэдэн компани оролцож болох талаар тодорхой шаардлага тавиагүй байна.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын дагуу, хоёр дугаар шатанд хамгийн их санал авсан компани нь газар өмчлөгч, эзэмшигчидтэй хэлцэл хийж, хоёр талт гэрээнд гарын үсэг зурах юм. Тухайн газрын талбайн хэмжээнээс шалтгаалан энэ ажлыг 30-60 хоногийн дотор хийж гүйцэтгэх ёстой.<sup>98</sup> ГХДБГ хоёр талт гэрээ байгуулах ажлыг дуусгах хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно (журмын 5 дугаар зүйлийн 5.6). Төсөл хэрэгжүүлэгч хоёр талт гэрээг тухайн талбай дээр оршин суугаа газар өмчлөгч, эзэмшигч бүртэй байгуулах ёстой.

---

<sup>96</sup> Эмнести Интернэшнлийн БХБЯ-тай хийсэн уулзалт, 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдөр.

<sup>97</sup> Гэр хорооллыг орон сууцжуулах төсөл нь оршин суугчдын өөрсдийнх нь санаачилгаар хэрэгжүүлэх дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэхээс гадна, гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах ажлыг давхар хариуцаж байна.

<sup>98</sup> Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.16 дахь хэсэг.

Гэрээ зурагдсаны дараа газар өмчлөгч, эзэмшигчид болон төсөл хэрэгжүүлэгч нар нийслэлийн Засаг даргатай гурван талт гэрээ байгуулах ёстой.<sup>99</sup>

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.1-д зааснаар, дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх хүсэлтэй компани нүүлгэн шилжүүлэлтийн нөхцөл болон нөхөх олговрын хэмжээг зөвшилцсөн хоёр талт гэрээг газар өмчлөгч, эзэмшигчдийн 80-аас доошгүй хувьтай байгуулсан байх ёстой. Гэвч Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.3.5-д 75-аас доошгүй хувийн дэмжлэг авсан байх ёстой гэсэн байна. Хэдийгээр ийм зөрчилдөөн байгаа боловч, ГХДБГ-ын Эмнести Интернэшнлд ярьснаар Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль батлагдсанаар хоёр талт гэрээгээр илэрхийлэгдэх олон нийтийн дэмжлэг нь 80 хувь байх юм байна.<sup>100</sup> Мөн тус газрынхан 30-60 хоног гэдэг нь оршин суугчдын 80 хувьтай гэрээ байгуулах хугацаа бөгөөд үлдсэн 20 хувийн дэмжлэгийг авахад цаг хугацааны хязгаар тавиагүй гэж Эмнести Интернэшнлд ярьсан юм.<sup>101</sup> Энэ нь Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15 дахь заалттай нийцэж байгаа бөгөөд төсөл хэрэгжүүлэгч “газар, эсвэл үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч болгонтой хоёр талт гэрээ байгуулах ёстой” гэж заасан байна.

## ХОЁР ТАЛТ ГЭРЭЭ

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам болон гэрээний загварын дагуу, хоёр талт гэрээнд дараах асуудлыг тусгах ёстой. Үүнд:

- Оролцогч хоёр талын тухай ерөнхий мэдээлэл – овог нэр, регистрын дугаар гэх мэт;
- Газар болон үл хөдлөх эд хөрөнгийн тухай ерөнхий мэдээлэл – талбайн хэмжээ, хаяг, ямар нэгэн үл хөдлөх эд хөрөнгө байгаа эсэх, газар өмчлөх, эзэмших гэрчилгээний дугаар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөлийн гэрчилгээний дугаар зэрэг багтана;

<sup>99</sup> Гурван талт гэрээ газар өмчлөгч, эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч, төрийн байгууллагын хооронд байгуулагдана. БХБ-ын Сайд 2016 оны 7 дугаар сарын 5-ны 125 дугаар тушаалаар дараах гурван талт гэрээний загваруудыг баталсан. Үүнд: Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”, “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”, “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар” болно. Энэ нь дахин төлөвлөлтийн төслийн онцлогоос хамаараад гурван талт гэрээ өөр өөр байна гэсэн үг юм.

<sup>100</sup> Эмнести Интернэшнлийн ГХДБГ-тай хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр.

<sup>101</sup> Эмнести Интернэшнлийн ГХДБГ-тай хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдөр.



- Нөхөх олговрын багц— жишээ нь, хэрэв газраа шинэ орон сууцаар сольж байгаа бол: байршил, давхар, өрөөний тоо болон талбайн хэмжээ, орон сууцны үнэ, ашиглалтанд орох хугацаа, орон сууцаа зарах, солих тохиолдолд хийх төлбөрийн нөхцөл гэх мэт мэдээлэл байна;
- Шинэ орон сууц ашиглалтанд орох хүртэл түр орон байрыг яаж шийдвэрлэх;
- Орон сууцаар сольж байгаа тохиолдолд түр оршин суух газрыг зохион байгуулах арга замууд;
- Төслийн хэрэгжилттэй холбоотой гарах эрсдэлүүдийг яаж шийдвэрлэх талаар;
- Маргааныг шийдвэрлэх арга замууд;
- Хоёр талын санал болгосон бусад нөхцлүүд;
- Хоёр талын гарын үсэг, тамга.<sup>102</sup>

Хоёр талт гэрээг байгуулсны дараа, нийслэлийн Засаг дарга төслийн төлөвлөгөөг хянаж батлана. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.2.г-д зааснаар, энэ үе шатанд гурван талт гэрээг гурван оролцогч тал болох төсөл хэрэгжүүлэгч, газар өмчлөгч, эзэмшигч, нийслэлийн Засаг дарга нар байгуулна.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.17-д хоёр болон гурван талт гэрээг байгуулах нь сайн дурын үндсэн дээр байх ёстой гэжээ. Гэвч журмын 4.16-д гурван талт гэрээ байгуулаагүй газар өмчлөгч, эзэмшигч нарт газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундаж үнээр нөхөх олговор олгож, газрыг чөлөөлнө гэж заасан байна. Тэгэхээр оршин суугчдад нэг бол гурван талт гэрээнд гарын үсэг зурах, эсвэл газраасаа хөөгдөх гэсэн сонголт л үлдэж байна. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын энэ заалт нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.3.в-д зааснаар газар, үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч гурван талт гэрээ байгуулаагүй тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч нөхөх олговортойгоор газар чөлөөлөх тухай нэхэмжлэл шүүхэд гаргах тухай заалттай зөрчилдөж байна.

Эмнести Интернэшнлд ГХДБГ ярихдаа, хэрэв газар өмчлөгч, эзэмшигчдийн 20 хувь нь төсөл хэрэгжүүлэгчтэй тохиролцоонд хүрч чадаагүй бол Засгийн газар тэдэнд олгох нөхөх олговрын хэмжээг тогтоох ёстой гэсэн юм. Түүнчлэн тус газраас Эмнести Интернэшнлд мэдээлснээр, дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд одоогоор газар чөлөөлөх үйл ажиллагаанд Засгийн газар оролцсон тохиолдол гараагүй байна.<sup>103</sup>

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.19-д гурван талт гэрээ байгуулахын өмнө төсөл хэрэгжүүлэгч нүүлгэн шилжүүлэлтийн

<sup>102</sup> Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.17 дахь хэсэг, нэмэлт мэдээллийг ГХДБГ-ын өгсөн мэдээлэл дээр үндэслэн хоёр талт гэрээ хийх загвараас авав; нбан бус орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

<sup>103</sup> Эмнести Интернэшнлийн ГХДБГ-тай хийсэн ярилцлага, 2016 оны 3 сарын 15-ны өдөр

ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Төслийн удирдах хороонд хүргүүлэх ёстой гэж заасан байдаг. Эмнести Интернэшнлийн уулзсан хоёр компани энэхүү төлөвлөгөө олон нийтэд нээлттэй биш байдаг гэж ярьсан юм.<sup>104</sup>

Гурван талт гэрээ байгуулсны дараа төслийг хэрэгжүүлэх үе шат эхлэнэ. Энэ үед л газар өмчлөгч, эзэмшигч нар газраа чөлөөлж эхлэх бөгөөд гурван талт гэрээ байгуулахаас татгалзсан иргэдийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа болох юм (Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.3.б, 14.7.3.в заалт, Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.16 дахь хэсэг). Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд зааснаар төсөл хэрэгжүүлэгч газар чөлөөлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах ёстой. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нүүлгэн шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэдэг байна. Гэвч бодит байдал дээр төсөл хэрэгжүүлэгч оршин суугчидтай тохиролцон гэрээ байгуулах хүртлээ хэлцэл хийсээр байдаг гэж ГХДБГ, барилгын гурван компаний төлөөлөл Эмнести Интернэшнлд ярьсан юм.

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.25-д заасны дагуу хэрэв төсөл хэрэгжүүлэгч 6 сарын дотор барилгын ажлыг эхлүүлээгүй, эсвэл дүрэм журмуудыг удаа дараа зөрчсөн, мөн гурван талт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Төслийн удирдах хорооноос төсөл хэрэгжүүлэгчийн тухайн талбайд дахин төлөвлөлт явуулах эрхийг цуцалж болно. Нийслэлийн Засаг дарга 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа явуулж байсан зургаан төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг цуцалсан байна.<sup>105</sup>

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмаар төслийг дуусгаж, хаах үе шатны талаар зохицуулаагүй. Гэвч Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.7.4.в-д төслийн хэрэгжилтийн тайлан, санхүүгийн бүртгэл, тооцоог гаргаж, гэрээний биелэлтийг дүгнэн Хяналтын хороогоор хэлэлцүүлж үнэлгээ, дүгнэлтийг гаргуулна гэж заажээ. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмын 5 дугаар зүйлийн 5.5-д ГХДБГ төслийн хэрэгжилтийг үнэлж, үр дүнгийн талаар жилд хоёр удаа тайлагнана гэж заажээ.

## **АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ БУУЛГАН ШИНЭЭР БАРИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Дахин төлөвлөлтийн бас нэг хэсэг нь ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулгах ажил юм. Энэ нь ашиглалтын шаардлага хангахгүй гэж тогтоогдсон нийтийн орон сууцны барилга юм.

---

<sup>104</sup> Эмнести Интернэшнлийн барилгын компаниудтай хийсэн уулзалт, 2016 оны 8 сарын 4, 10-ны өдөр.

<sup>105</sup> Нийслэлийн Засаг даргын 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/566, А/568, А/569, А/570, А/571, А/572 дугаар захирамж; албан бус англи орчуулга Эмнести Интернэшнлийн архивт байгаа.

Орон сууц хувьчлах ажил 1997 онд эхэлсэн бөгөөд Улаанбаатар хотын олон оршин суугч өөрийн байрыг хувьчилж авах боломж бүрдсэн билээ.<sup>106</sup> Гэвч орон сууцны зориулалттай эдгээр барилгын олонх нь чанар муутай баригдсан, яаралтай засвар хийх шаардлагатай байна. Зарим барилга нь бие засах газар, цэвэр усны хангамж гэх мэт наад захын дэд бүтэцгүй байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журамд шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөх төслийг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой алхмуудыг зааж өгчээ. Энэ журмыг БХБ-ын Сайд 2016 оны 7 дугаар сарын 5-нд баталжээ. Энэ нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор 2014 оны 6 дугаар сарын 9-нд батлагдсан Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөх үйл ажиллагааны журмыг хүчингүй болгож, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг дахин төлөвлөхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулна. Журмын дагуу, шинэ орон сууцны барилга барих дахин төлөвлөлтийн төслийн санал болгонд орон сууц өмчлөгчийг хуучин орон сууцны хэмжээтэй ижил эсвэл түүнээс илүү хэмжээтэй орон сууцаар хангана гэж заасан байна. Энэхүү үйл явцыг НЕТГ хянах ёстой. Энэ журмын хэрэгжилт бодит байдал дээр ямар байгаа талаар үнэлгээ өгөхөд арай эрт байна.

НЕТГ-ын хэлснээр нийтийн орон сууцны барилгыг дахин төлөвлөлтийн төсөлд хамруулахын өмнө тухайн барилга ашиглалтын шаардлага хангахгүй болсон гэсэн үнэлгээ, дүгнэлтийг Мэргэжлийн хяналтын байгууллага гаргаж, орон сууц өмчлөгчид болон нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ. Үнэлгээний тайлан болон Засгийн газрын бусад байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн нийслэлийн Засаг дарга барилгын дахин төлөвлөлтийг хийх эсэх шийдвэрийг гаргана.<sup>107</sup>

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т нийслэлийн Засаг дарга барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн барилга байгууламжийг ашиглахыг хориглосон шийдвэр гаргана гэжээ. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.2-т “Засаг дарга ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцанд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр барилга баригдаж, ашиглалтад орох хүртэл түр түдгэлзүүлэх” шийдвэр гаргана гэж заасан байна.

Орон сууц өмчлөгч нар байраа дахин төлөвлөлтийн төсөлд хамруулах тухай хүсэлтийг Нийслэлийн Засаг даргад 14 хоногийн дотор гаргаж өгнө (Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.4). Түүнчлэн, тус журмын 3 дугаар зүйлийн 3.5-д уг хүсэлтийг нийт орон сууц өмчлөгчдийн 80-аас доошгүй хувь нь дэмжсэн байх ёстой гэж заажээ.

---

<sup>106</sup> Б.Чинзориг, Монгол Улсын газрын хувьчлал: Ази, Номхон далайн бүсийн газрын харилцааг зохицуулахад гарч буй асуудлууд, хандлагын талаарх олон улсын семинар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, 2008 оны 8 дугаар сарын 19-20-ны өдөр.

<sup>107</sup> Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын 2 дугаар бүлэг нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцыг тодорхойлсон.

Төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах гэх мэт төслийг хэрэгжүүлэх үйл явц нь Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу зохион байгуулагдана (хуулийн 1 дүгээр зүйлийн 1.4, 4 дүгээр зүйлийн 4.2). Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6-д “төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулахдаа Үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг явуулна” гэж заасан байна. Уг журам энэ заалтыг улам дэлгэрүүлж, хорооны бүрэлдэхүүнд орон сууц өмчлөгчдийн төлөөлөл байх ёстой, хороо нь шийдвэрээ 30 хоногийн дотор гаргана гэж тусгажээ (Тус журмын 4 дүгээр зүйлийн 4.4, 4.5).

Үнэлгээний хороо шийдвэрээ гаргасны дараа шалгарсан компани нь орон сууц өмчлөгчидтэй хэлцэл хийж, хоёр талт гэрээ байгуулах эрхтэй болно (Тус журмын 4 дүгээр зүйлийн 4.8). Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журмаас ялгаатай нь шалгарсан компани нь төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлөө авсны дараа л хоёр талт гэрээ байгуулах эрхтэй болж байна.

## ХОЁР ТАЛТ ГЭРЭЭ

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын дагуу, хоёр талт гэрээнд дараах зүйлийг тусгасан байх хэрэгтэй. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийг өмчлөгчийн тухай ерөнхий мэдээлэл;
- Газар болон үл хөдлөх хөрөнгийн тухай ерөнхий мэдээлэл;
- Борлуулж худалдан авах гэрээ хийсэн тохиолдолд төлбөр хийх хугацаа;
- Санал болгож буй шинэ орон сууцны тухай мэдээлэл, тухайлбал хэдэн давхарт, хэдэн өрөө, байрны хэмжээ, орон сууцыг хэзээ ашиглалтанд оруулж хүлээлгэж өгөх хугацаа зэрэг;
- Нүүхтэй холбоотой гарах зардал, үүнийг хаанаас гаргах талаар зөвшилцөх;
- Түр оршин суух газрын талаар зөвшилцөх;
- Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болох бусад эрсдэлүүдийг хэрхэн шийдвэрлэх арга зам;
- Хоёр талын гарын үсэг, тамга, огноо;
- Бусад мэдээлэл.<sup>108</sup>

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журамд нүүлгэн шилжүүлэлтийн тухай дурьдаагүй байна. Журмын 5 дугаар зүйлийн 5.6-д төсөл хэрэгжүүлэгч “гурван талт гэрээ байгуулаагүй үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчтэй төслийн аль ч үе шатанд тохиролцох, ойлголцолд хүрэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэжээ. Төсөл хэрэгжүүлэгч болон орон сууц өмчлөгч нар тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд яах вэ гэдэг заалт журамд огт дурьдагдаагүй байгаа бөгөөд энэ талаар Хот, суурин

<sup>108</sup> Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.11 дэх хэсэг.

газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7.3.в-д хэрэв тохиролцоонд хүрч чадаагүй бол төсөл хэрэгжүүлэгч шүүхэд хүсэлт гаргах эрхтэй гэж заасан байдгийг өмнө нь дурдсан билээ.

Тус журамд “сууц өмчлөгчийн амь нас, эд хөрөнгө, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахын тулд тухайн орон сууцны цэвэр, бохир ус, дулаан, эрчим хүчний хэрэглээ, үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох хүртэл арга хэмжээг эрх бүхий байгууллага авч хэрэгжүүлнэ” гэж заажээ. Энэ зүйлд ус, дулаан, эрчим хүчийг хязгаарлахаас өмнө ямар арга хэмжээг авах талаар ямар нэгэн мэдээлэл өгөөгүй байна. Хэрэв ийм арга хэмжээг авах гэж байгаа бол хэзээ хийх гэж байгаа талаар мэдээлэл өгөх, энэ нь хүмүүсийн хамгийн наад захын энгийн үйлчилгээ авах эрхийг хязгаарлах ёсгүй эсвэл шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийн нэг хэсэг болсон наад захын үйлчилгээг сайн дураар хязгаарлах, тасдах явдлаас хамгаалагдахыг баталгаажуулах ёстой.

### 3. ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУД

Дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилтийг төвийн болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд хянах үүрэгтэй. Төвийн түвшинд төслийн хэрэгжилт хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж байгаа бол, нийслэлийн удирдлагууд, ялангуяа Засаг дарга дахин төлөвлөлтийн төсөл саадгүй хэрэгжих, ямар нэгэн асуудал, эсвэл гомдол гарсан тохиолдолд шийдвэрлэх үүрэгтэй оролцож байна.

Нийслэл,<sup>109</sup> аймгийн Засаг дарга нар Хот байгуулалтын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн аль алины дагуу тодорхой үүрэг хүлээж байна. Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу нийслэлийн Засаг дарга дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- хот, тосгоны батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгажилтын төслийг үндэслэн газар олгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- аймаг, нийслэлийн ерөнхий архитекторыг 4 жилийн хугацаагаар томилох;
- ерөнхий архитектороор удирдуулсан Хот байгуулалт, барилга захиалагчийн албыг байгуулах;
- аймаг, нийслэлийн хөгжлийн төсөл, хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгол, шинэчлэл хийх асуудлыг санаачлан зохион байгуулах;
- хот байгуулалтын үйл ажиллагаа болон газар ашиглалт, хамгаалалтад хяналт тавих;
- хот байгуулалтын чиглэлээр хийгдсэн ажлын талаарх тайланг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жилд нэг удаа ирүүлэх.

Харин Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу, Нийслэлийн Засаг дарга хот, суурин газрыг дахин хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

---

<sup>109</sup> Нийслэл хотын эрх зүйн байдлын тухай хуульд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нь нэг хүн байж болно, гэхдээ нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хотын захирагчийн алба нь тусдаа үйл ажиллагаа явуулах ёстой гэж заажээ.

- хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн төсөл санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- улс, орон нутгийн төсвөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх;
- төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах;
- төсөл хэрэгжүүлэх гурван талт гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах;
- төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг нийтэд сурталчлах, мэдээллэх, санал, гомдол хүлээн авах замаар олон нийтийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах;
- сэргээн босголтын үйл ажиллагааг Засгийн газрын шийдвэрээр хэрэгжүүлэх;
- газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч иргэн, хуулийн этгээдтэй аймаг, нийслэлийн Засаг дарга гурван талт гэрээ байгуулна.

Тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-д төсөл хэрэгжүүлэгчийн дампуурлыг шүүхээс зарласан тохиолдолд төслийг үргэлжлүүлэн дуусгах арга хэмжээг нийслэлийн Засаг дарга зохион байгуулах үүрэгтэй.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нийслэлийн Засаг дарга дахин төлөвлөлттэй холбоотой үүргээ биелүүлж байгаа эсэхийг хянах, баталгаажуулах юм. Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу нийслэлийн (аймгийн) иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот байгуулалт болон дахин төлөвлөлттэй холбоотой баримт бичгийг батлах, дахин төлөвлөлтийн төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв хөрөнгийг хуваарилах, нийслэлийн Засаг даргын хамтаар хот байгуулалт, дахин төлөвлөлтийн баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, хотын шинэ хороолол, бичил хороолол, гэр хороолол болон бусад хуучин дүүргүүдийг хөгжүүлэх шийдвэрийг гаргана.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төсөл хэрэгжүүлэх талбайн байршил, хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоож, шийдвэр гаргах, орон нутгийн төсвөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг нийслэлийн Засаг даргын оруулсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үүргийг зааж өгсөн байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал завсарласан үед иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид эдгээр үүргийг хэрэгжүүлдэг.

Үндэсний түвшинд БХБЯ төрийн түвшний бодлогыг тодорхойлж, хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянах үүргийг хүлээнэ. Тус яам нь орон нутгийн түвшинд дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх талбайг сонгох, хэрэгжүүлэхтэй холбоотой журмуудыг батлах, төндэрийн үйл явц журмын дагуу явагдаагүй гэж үзэх юм бол дахин төлөвлөлт явуулах зөвшөөрлийг цуцлах эрхтэй.<sup>110</sup> Түүнчлэн, тус яам нь хот, суурин газрыг дахин төлөвлөхөд зааварчлах, дэмжлэг үзүүлэх, төрийн түвшинд нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хянах ажлыг хийнэ.

---

110 Эмнести Интернэшнлийн БХБЯ-тай хийсэн ярилцлага, 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдөр.



**ЭМНЕСТИ**  
**ИНТЕРНЭШНЛ**



[www.amnesty.org](http://www.amnesty.org)



# FALLING SHORT

THE RIGHT TO ADEQUATE  
HOUSING IN  
ULAANBAATAR, MONGOLIA

**AMNESTY**  
INTERNATIONAL



Amnesty International Publications

First published in 2016 by  
Amnesty International Publications  
International Secretariat  
Peter Benenson House  
1 Easton Street  
London WC1X 0DW  
United Kingdom  
[www.amnesty.org](http://www.amnesty.org)

© Amnesty International Publications 2016

Index: ASA 30/4933/2016  
Original Language: English  
Printed by Amnesty International, International Secretariat, United Kingdom

[ISBN:]

[ISSN:]

All rights reserved. This publication is copyright, but may be reproduced by any method without fee for advocacy, campaigning and teaching purposes, but not for resale. The copyright holders request that all such use be registered with them for impact assessment purposes. For copying in any other circumstances, or for reuse in other publications, or for translation or adaptation, prior written permission must be obtained from the publishers, and a fee may be payable. To request permission, or for any other inquiries, please contact [copyright@amnesty.org](mailto:copyright@amnesty.org)

Cover photo: Amnesty International

